



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2017 • XII • № 14

**МОНГОЛБАНК ОЛОН
УЛСЫН ТӨВ БАНКНЫ
ЖИШИГТ ХҮРЭХЭЭР
ШИНЭЧЛЭЛТ
ЭХЛҮҮЛЛЭЭ**

**О.ЭРДЭМБИЛЭГ:
БОДЛОГЫН ХУВЬД
ТУУШТАЙ ЯВСНЫ
ҮР ДҮНД СОРИЛТ
ИХТЭЙ ЖИЛИЙГ
АМЖИЛТТАЙ
ДАВАН ТУУЛЛАА**

**АКТИВЫН
ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ
ГЭЖ ЮУ ВЭ?**

**БАНКНЫ
САЛБАРЫН
БОЛЗОШГҮЙ
ХҮНДРЭЛҮҮД,
ШИЙДВЭРЛЭХ АРГА
ЗАМУУД**

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Бодлогын хүүг бууруулах тухай

Дугаар: 2017/04

Мөрдөх огноо: 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хуралдаж, бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж 11.0 хувь болгох шийдвэр гаргалаа.

2017 оны 11 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 6.5 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 7.6 хувь байгаа хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх жилийн инфляци дунд хугацаанд Төв банкны зорилтот 8 хувийн түвшинд тогтвортой байхаар байна.

Энэ оны эхний гурван улиралд эдийн засаг хүлээлтээс давж өслөө. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, бүтээн байгуулалт эрчимжиж, гадаад худалдааны нөхцөл сайжирч, богино хугацааны гадаад өрийн эргэн төлөлтийн дарамт буурч байгаагаас макро эдийн засгийн эрсдэл буурч, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байна. Эдийн засгийн цаашдын төлөвөөс харахад бизнесийн зээл, уул уурхайгаас хамаарал багатай салбаруудын өсөлтийг дэмжих, ажилгүйдлийн түвшинг бууруулах шаардлага хэвээр байна.

Мөнгөний бодлогыг зөөлрүүлэх энэхүү шийдвэр нь эдийн засгийн өсөлт, бизнесийн идэвхжил болон ажил эрхлэлтэд дэмжлэг үзүүлнэ.

Зөвлөлийн хурлын хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ

Нэгэн жилийн түүхийг бүтээж, дахин шинийг эрэлхийлэх эрч хүчээр хөглөгдөн буй эрхэм уншигч Танд “Монголбанкны мэдээлэл” товхимлын 2017 оны отгон дугаараа өргөн барьж байна.

Монгол Улсын мөнгө, санхүүгийн системийн зүрх нь болсон Монгол Улсын Төв банк Монголбанкны бодлого үйл ажиллагаа нь зөвхөн шийдвэр гаргагчид, санхүүгийн зах зээлд оройлон оролцогчдын хүрээнд бус эгэл түмэнд ч хамаатай билээ. Өндөр хөгжсөн улс орнуудад ард түмэн нь төв банкныхаа бодлого үйл ажиллагааг сайн мэддэг гэсэн судалгаа бий. Тийм учраас Монголбанкны түлхүүр бодлого болох Мөнгөний бодлогыг бага балчираас өтгөс буурал нь хүртэл ойлгож, иргэний хяналт тавьж байх мэдлэг манай иргэдэд хэрэгтэй байна. Ингэж гэмээ нь төв банк хараат бусаар бодлого боловсруулахад олон түмнээс дэмжих хөшүүрэг бий болно. Үүний тулд Монголбанк

2017 онд олон нийттэй харилцах харилцаагаа шинэ түвшинд хүргэж, ил тод нээлттэй байдлаа хангаж ажилласны нэг хэлбэр нь энэхүү “товхимол” байлаа.

Улиран одож буй 2017 он Монгол Улсын хувьд эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг сөрөх амаргүй сорилтуудтай тулгарсан жил байв. Хугацаа нь тулсан гадаад өр төлбөрийг эдийн засагт сөрөг нөлөө багатайгаар шийдвэрлэх, макро эдийн засгийг тогтворжуулж, цаашид тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө чармайн ажилласны үр дүнд монгол түмэн бид хамтдаа сорилтыг амжилттай даван туулж байна. Өнгөрсөн оны гуравдугаар улиралд эдийн засаг -1.4 хувийн уналттай, -0.8 хувийн дефляцитай байсан бол 2017 оны дөрөвдүгээр улирлын байдлаар эдийн засаг 5.8 хувиар өсч, инфляци 6.5 хувьд хүрч, гадаад валютын албан нөөц 3.0 тэрбум ам.доллар болж өмнөх оны мөн үеийнхээс 3 дахин

нэмэгдсэн зэрэг эерэг үзүүлэлтүүд гарч, Монголбанк мөнгөний бодлогын зорилтоо амжилттай биелүүллээ. Үүгээр зогсохгүй Монгол төгрөгийн үнэ үнэ цэнэ, худалдан авах чадварыг хадгалах, үүний тулд санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтоо хангахын тулд Монголбанк эдийн засаг, банк, санхүүгийн тогтолцоонд үүссэн асуудлыг шийдвэрлэх цогц арга хэмжээг төрийн бусад шийдвэрт үндэслэн авч эхэлсэн бөгөөд үүний нэг хэсэг нь “Банкны салбарын хууль эрх зүйн шинэтгэл”-ийг эхлүүлсэн явдал байлаа.

Монголбанк ирэх 2018 оныг Монгол Улсын банк, санхүүгийн салбарын хөгжлийн шинэ эхлэлгэж харж байна.

Монголбанк нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгож, санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг бэхжүүлэн, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх үйлст идэвх зүтгэлтэй оролцох болно.

Өвөр дүүрэн баялаг өвөлсөн Монгол түмний минь заяа тэгш, мэлмий хурц, үйл нь дэлгэр байж
2018 ондоо өөдлөн дэвжиж, өнгөжин жавхаажихыг хүсэн ерөөе!

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох мэдээ:

Монголбанкны олон улсын төв банкны жишигт хүрэхээр шинэчлэлт эхлүүлээ

ХУУДАС

5

Ярилцлага:

О.Эрдэмбилэг: Бодлогын хувьд тууштай явсны үр дүнд сорилт ихтэй жилийг амжилттай даван тууллаа

ХУУДАС

9

Инфографик:

Активын чанарын үнэлгээ

ХУУДАС

12

Асуулт, хариулт:

Активын чанарын үнэлгээний талаар таны мэдэх зүйлс

ХУУДАС

14

Нийтлэл:

Тогтворжилт, өсөлтийн зүгт

ХУУДАС

17

**Монголбанкны
Эрдэнэсийн сангаас:**

Аргалийн толгойтой хос алтан сүлбээр

ХУУДАС

21

Орон нутаг:

Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар

ХУУДАС

22

Мөнгөн тэмдэгтийн түүх:

1937 оны гүйлгээний зоосон мөнгө

ХУУДАС

25

Банкир:

Бен Бернанке: Хямралын хар мөр

ХУУДАС

26

Дэлхийн эдийн засаг:

2018 оны Нобелийн шагнал Пол кругма ба гадаад худалдааны онолд хийсэн түүний нээлт

ХУУДАС

30

Судалгаа:

Банкны салбарын болзошгүй хүндрэл, шийдвэрлэх арга замууд

ХУУДАС

32

Санхүүгийн боловсрол:

Бага насны хүүхдэд санхүүгийн мэдлэг, боловсрол олгох асуудалд

ХУУДАС

35

МОНГОЛБАНК ОЛОН УЛСЫН ТӨВ БАНКНЫ ЖИШИГТ ХҮРЭХЭЭР ШИНЭЧЛЭЛТ ЭХЛҮҮМЭЭ

Монголбанкны 2017 оны онцлох 17 үйл явдлын товчоон

1. Эдийн засгийн уналтаас өсөлтөд шилжих Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, инфляцийг тогтворжуулах зорилтыг хангах нөхцөл бүрдлээ.

Засгийн газар Монголбанк хамтран “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” хэрэгжүүлснээр өнгөрсөн оны 3 дугаар улиралд эдийн засаг -1.4 хувийн уналттай, -0.8 хувийн дефляцитай, богино хугацаанд төлөх гадаад, дотоод төлбөрийн асуудлууд тулсан зэрэг хүндрэлүүдийг шийдвэрлэж, 2017 оны 11 дүгээр сарын байдлаар инфляцийн түвшин улсын хэмжээнд 6.5, Улаанбаатар хотын хэмжээнд 7.6 хувь буюу зорилтот түвшинд хадгалагдаж, эдийн засаг 5.8 хувиар өсөөд байна. Урт хугацааг харсан төсөв, мөнгөний мөнгөний бодлого, уул уурхайн томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт, Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн хөтөлбөрийн нөлөөгөөр эдийн засгийн төлөв сайжирч байгаа боловч ажилгүйдэл өндөр хэвээр, шинээр олгож буй зээл ажлын байр шинээр бий болгоход бус, өрхийн хэрэглээг санхүүжүүлэхэд чиглэгдэж байна. Иймд 2017 онд Монголбанкнаас мөнгөний бодлогыг зөөлрүүлж, бизнесийн салбарыг дэмжих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хадгалах чиглэлд шат дараатай бодлогын шийдвэр, арга хэмжээ авч 6 дугаар сард бодлогын хүүг 2 нэгж хувиар, 12 дугаар сард 1 нэгж хувиар бууруулж, 11.0 хувьд хүргэв. Мөн бодлогын хүүний коридорыг тэгш хэмтэйгээр тогтоолоо. Энэхүү шийдвэрүүд нь инфляцийг дунд хугацаанд тогтворжуулах зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн өсөлт, идэвхжил, ажил эрхлэлт, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх юм.

2. ОУВС-ийн дэмжлэгтэйгээр эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулах Засгийн газрын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг Монголбанк дэмжин хамтран хэрэгжүүлж эхэллээ.

Монгол Улс 2017 оны 5 дугаар сарын 24-нд ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдаж, эдийн засгийг богино хугацаанд тогтворжуулж, цаашид тогтвортой өсөх суурийг тавихаар 2017-2020 онд баримтлах макро эдийн засгийн цогц бодлогыг тодорхойлж, ил тод нээлттэй хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Монголбанк Засгийн газрыг дэмжин ажиллаж, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, олон улсын зах зээлээс мөнгөн хөрөнгө татахад хамтран ажиллалаа. Хөтөлбөрийн хүрээнд ОУВС болон донор орнуудаас нийт 5.5 тэрбум ам.долларын

санхүүжилт шийдэгдэхээр болж, хөтөлбөрийн нэг, хоёр дахь шатыг амжилттай хэрэгжүүлснээр нийт 700 гаруй сая ам.долларын санхүүжилтийг авсан нь эдийн засагт тулгараад буй асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг болж байна.

3. Хугацаа нь тулсан Хөгжлийн банкны бондыг богино хугацаанд шийдвэрлэж, Засгийн газрын бондоор сольсноор Монгол Улсыг дампуурал зарлахаас сэргийлэх арга хэмжээг Засгийн газартай хамтран авлаа.

Монгол Улсын Засгийн газар 2017 оны 3 дугаар сард олон улсын зах зээл дээр 600 сая ам.долларын “Хуралдай” бонд гаргалаа. Тус бондын 82 хувь буюу 476 сая ам.долларыг Хөгжлийн банкны Евро бондын эзэмшигчдэд сольж өгсөн бол үлдсэн 18 хувь буюу 124 сая ам.долларыг хөрөнгө оруулагчдад 7 жилийн хугацаатай 8.75 хувийн хүүтэйгээр арилжаалав. Ингэснээр Засгийн газар Монгол Улсын Гадаад валютын нөөцөөс нэг ч ам.доллар гарздахгүйгээр Хөгжлийн банкны 580 сая ам.долларын хугацаа нь тулсан өр төлбөрийг шийдэж, Монгол Улсыг дефолтод орох эрсдэлээс хамгааллаа.

4. Хятадын Ардын банкт хийсэн своп хэлцлийн хугацааг гурван жилээр сунгаж төлбөрийг хойшлуулснаар дунд хугацаанд дарамт багатай шийдвэрлэх боломжийг бүрдүүлээ.

Монголбанк болон Хятадын Ардын Банк хооронд хоёр орны худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгуулсан 15 тэрбум юань бүхий 5.4 их наяд төгрөгийн своп хэлцлийн гэрээг 2017 оны 7 дугаар сарын 6-ны өдөр шинэчлэн баталлаа. Своп хэлцлийн эргэн төлөлтийн хугацааг 3 жилээр сунгаж, хоёр тал харилцан зөвшилцөлд хүрсэн тохиолдолд дахин шинэчлэх боломжтой болов.

5. Европын төв банкнаас гаргасан аргачлалын дагуу банкны системд активын чанарын иж бүрэн үнэлгээг анх удаа хийснээр, эрсдлээс урьдчилан сэргийлэх чадавхийг бүрдүүлэв.

ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсын банкны системийн “эрүүл мэндийг оношлох”, зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор арилжааны банкуудад анх удаа активын чанарын үнэлгээг хийв.

Монголбанкнаас олон улсад нээлттэй тендер зарласнаар РwC олон улсын аудитын компанийн Чех улсын салбар сонгогдож, банкуудын активын чанарын үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Банкны системийн активын чанарын үнэлгээг олон улсын хөндлөнгийн байгууллагаар олон улсын стандартын дагуу хийлгэснээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах суурь нөхцөл бүрдэх юм. Энэхүү үнэлгээний үр дүнд банкууд өөрийн активыг зохистой үнэлэх, эргэн төлөлтийн доголдолтой активаас үүсэж болзошгүй алдагдлыг даах хангалттай хэмжээний өөрийн хөрөнгөтэй байлгахад чиглэсэн арга хэмжээ авах боломжтой болов.

6. Ойрын хугацаанд төлөгдөхөөр хүлээгдэж байсан өрийг хаах, шинэ эх үүсвэрийг Олон Улсын зах зээлээс хүү бага, хугацаа урт эх үүсвэрийг амжилттай татахад Засгийн газар Монголбанк хамтран ажиллав.

Монгол Улс олон улсын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах хэлэлцээрийг амжилттай хийснээр 2017 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр 5.625 хувийн хүүтэй 5.5 жилийн хугацаатай 800 сая ам.долларын санхүүжилтийг Монголбанк Засгийн газартай хамтран олон улсын санхүүгийн зах зээлээс татлаа. Энэхүү бондын хүү Засгийн газрын өмнө нь гаргаж байсан “ДимСам” /7.5% хүү, 3 жил/, “Мазаалай” /10.8% хүү, 5 жил/ зэрэг бондуудын хүүнээс харьцангуй бага хүүтэй, урт хугацаатай гарснаараа онцлог бөгөөд бондын санхүүжилт 2018 онд төлөгдөх Чингис болон ДимСам бондуудын эргэн төлөлтийг хийхэд зарцуулагдана. Ийнхүү 2017 онд Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бонд, Хятадын Ардын банктai хийсэн 15 тэрбум юанийн своп хэлцэл, Чингис бонд болон ДимСам бондын эргэн төлөлт шийдвэрлэгдсэнээр Монгол Улсад 2020 он хүртэл гадаад төлбөрийн эргэн төлөлтийн дарамтаас гарах нөхцөл бүрдэв.

7. Монгол Улсын Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудтай хамтран Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр батлуулж, Монгол Улсыг саарал жагсаалтад орохоос сэргийлэв.

ФАТФ-ын Ази, Номхон далайн бүсийн байгууллагаас хийсэн харилцан үнэлгээний тайлангийн үр дүнгээр Монгол Улсыг 2018 оны 10 дугаар сараас өмнө хууль, эрх зүйн орчноо ФАТФ-ын стандарт, зөвлөмжтэй нийцүүлэх үүргийг Монгол Улсад өгснөөр саарал жагсаалтад шууд орохоос сэргийлж чадлаа. Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-наас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл

байгуулав. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл “Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай” 19/15 дугаар зөвлөмж гаргасны дагуу ФАТФ-ын зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, Засгийн газраас “Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах ажлын төлөвлөгөө”-г 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдөр батлууллаа. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд төрийн байгууллагууд идэвхтэй хамтран ажиллаж эхлэв.

8. Харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны системийг эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд хууль эрх зүйн орчныг сайжруулахаар “Банкны салбарын хууль, эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөр”-ийг баталж, 11 багц хуулийн төсөл шинэчлэн боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлж эхэллээ

Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг бүрдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үр дүнг бэхжүүлэх чиглэлийн хүрээнд банкны салбарын гол хуулиудыг шинэчлэх зорилт бүхий хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан хуулийн төслүүдээс Үндэсний төлбөрийн системийн тухайн хуулийг УИХ-аар батлуулан 2018 оны 1-р сарын 1-ний өдрөөс мөрдөгдөхөөр боллоо. Мөн Монголбанкны бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, банкны зохистой засаглалыг бүрдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тогтворжуулах, бүтцийн өөрчлөлт хийх зэрэг оролцооны арга хэмжээг тусгасан Банкны тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдийг тус тус УИХ-аар хэлэлцүүлж байна. Үүний дараа Банкны дахин хөрөнгөжүүлэлтийн тухай, Активын удирдлагын тухай хуулийн төсөл, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Валютын зохицуулалтын тухай, Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай болон Векселийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг тус тус боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлэн боллоо.

9. Валютын захын дэд бүтцийг хөгжүүлж, банк хоорондын цахим арилжааг нэвтрүүлснээр валютын захын ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүллээ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлд “Валютын дотоодын захын дэд бүтцийг

хөгжүүлэх арга хэмжээ"-г авч ажиллахаар заасны дагуу Монголбанкнаас "Банк хоорондын валют арилжааны цахим талбар"-ыг 2017 оны 4 дүгээр сарын 10-ний өдөр амжилттай нэвтрүүлээ. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэлд эдийн засгийн хүчин зүйлсээс гадна санхүүгийн захын дэд бүтэц, тэр дундаа валютын захын дэд бүтэц, түүний нэгдмэл бус байдал сөргөөр нөлөөлж байсныг ийнхүү шийдвэрлэж чадлаа. Ингэснээр 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 300.0 орчим сая ам.доллартай тэнцэхүйц хэмжээний ам.доллар болон юанийн арилжааг банкууд хоорондоо цахим талбараар хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 дахин өссөн үзүүлэлт юм. Энэхүү цахим арилжааны талбарт арилжааны банкуудаас гадна иргэд, аж ахуйн нэгжүүд, Банк бус санхүүгийн байгууллагууд харилцагч банкаараа дамжуулан оролцох бүрэн боломжтой ба гадаад валютын арилжаанд идэвхтэй оролцдог дотоодын экспортлогч, импортлогч байгууллагууд талархан хүлээн авч байна.

10. Гадаад валютын улсын нөөц 3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3 дахин өсч, 20 тонн алт худалдан авснаар Монгол төгрөгийн тогтвортой байдлыг баталгаажуулав.

Гадаад валютын улсын нөөц 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 133 хувиар тус өслөө. Нөөц ийнхүү нэмэгдэхэд нэгдүгээрт Монголбанк алт, мөнгө худалдан авах үнийг дэлхийн зах зээлийн ханштай нийцүүлснээр нийт худалдан авсан алт 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 20.0 тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 9 хувиар өссөн үзүүлэлт юм. Энэ нь Монголбанкны сүүлийн жилүүдэд худалсан алтны түүхэн дээд хэмжээ аж. Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газраас Олон улсын хөрөнгийн захад "Хуралдай" бонд болон "Гэрэгэ" бондыг амжилттай гаргасан бол гуравдугаарт, ОУВС-ийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд ОУВС болон донор орнуудаас 700 сая гаруй ам.долларын санхүүжилт орж ирсэн, дөрөвдүгээрт, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээснээр хувийн секторт гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлөв. Түүнчлэн Монголбанкинд тушаасан алтны биет хэмжээний өсөлтөөс гадна дэлхийн зах зээл дээрх алтны үнэ оны эхнээс 10 орчим хувиар өссөн нь алтны орлого нэмэгдэх, цаашилбал нөөц өсөхөд эерэг нөлөө үзүүлээ.

11. Эдийн засгийн хүндрэлээс богино хугацаанд гарах бодлого, шийдвэрийн нөлөө, үр дүнд Монголбанк сүүлийн 5 жилд анх удаа алдагдалгүй ажиллалаа.

Эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, банк, санхүү,

бизнесийн орчинд эерэг таатай хандлага, хүлээлт бий болсонтой холбогдуулан мөнгөний бодлого, валютын ханш, дотоод, гадаад сектор, гэрээ, хэлцлийн хүрээнд Монголбанкнаас шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд мөнгө, санхүү, эдийн засгийн зарим голлох үзүүлэлтүүд өссөний зэрэгцээ өмнөх 2012-2016 онуудад хуримтлагдсан Монголбанкны нийт алдагдлыг нэмэгдүүлэлгүйгээр 2017 онд Монголбанк алдагдалгүй ажиллалаа.

12. Үйл ажиллагааны шинэчлэлтэд зорьсон дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх болсон нь Монгол Улсын Төв банкны түүхэнд анх удаа хийгдэж буй ажил боллоо.

Монголбанкны үйл ажиллагаанд тулгамдаж буй болон цаашид өөрчлөх, шинээр нэвтрүүлэх ажлуудыг тодорхойлон дунд хугацаа /2017-2019 он/-нд баримтлах "Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөр"-ийг боловсруулан амжилттай хэрэгжүүлж эхэллээ. Уг хөтөлбөр нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах, засаглал, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, дэвшилтэт технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх гэсэн үндсэн таван чиглэлд төвлөрч байна. Энэхүү бодлогын зорилт нь Монголбанкны хувьд анх удаа авч хэрэгжүүлж буй стратегийн ач холбогдол бүхий олон улсын төв банкуудтай хөл зэрэгцэн очих томоохон алхам болж байна.

13. Хөрш орны Төв банкуудтай хамтын ажиллагаагаа цоо шинэ шатанд авчрах ажлыг амжилттай эхлүүллээ

Монголбанк эдийн засгийн хүндрэлийг даван туулахад хоёр хөршийн төв банкуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх тусгайлсан дугуй ширээний уулзалтуудыг 6, 7 дугаар сард Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав. Уулзалтын үеэр хоёр орны, эдийн засаг, худалдаа, банкны салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн яриа хэлцлүүд хийгдлээ. БНХАУ-тай хоёр улсын мөнгөн тэмдэгт харилцан солилцох своп хэлцлийн үр дүн, БНХАУ-ын макро эдийн засгийн нөхцөл байдал болон "Бүс зам" санаачлагын талаар, ОХУ-тай "Үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцэл" байгуулах асуудлаар, Банк хоорондын хил дамнасан төлбөр тооцооны системийг хөгжүүлэх, ОХУ-ын хилийн ойролцоох арилжааны банкуудаас бэлэн рубль импортлох боломжийг Монголын банкуудад олгох тухай асуудлаар тус тус байр сууриа илэрхийлж, харилцан хэрэгжүүлэх шатанд анхаарлаа хандуулахаар санал солилцлоо.

14. Монголбанкны бодлого, үйл ажиллагааг ил тод нээлттэй болгож, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх,

соён гэгээрүүлэх, нийтийг хамарсан шат дараатай ажлуудыг хийж, хэрэгжүүлэв.

Мөнгөний бодлогын талаарх олон нийтийн ойлголт, ил тод байдлаа нэмэгдүүлэхэд анхаарч ажилласнаар Монголбанк нь өөрийн нэрийн мэдээллийн бүтээгдэхүүнүүдтэй боллоо. Үүнд мөнгөний бодлого, эдийн засгийн мэдээллийг энгийнээр тайлбарласан сар тутмын “Монголбанкны мэдээлэл” товхимол, улирал тутам гардаг онол арга зүй, судалгааны “Мөнгө-Баялаг-Санхүү” сэтгүүлийг тус тус эрхлэн гаргаж, уншигчдын гарт хүргэв. Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр цаг үе, үйл ажиллагааны талаар мэдээллийг цаг тухайд нь хүргэж, Bloomberg, Eagle телевизүүдээр 14 хоног тутамд гарах нэвтрүүлгүүдийг бэлтгэж өөрийн анхдагч эх сурвалжаар үзэгчдийн анхааралд хүргэдэг боллоо. Мөн веб хуудсаа 2017 онд шинэчлэн сайжруулж, “Монголбанк” болон “Төсөвчин” аппликейшнүүдийг гар утасны iOS болон андройд үйлдлийн системүүд дээр гаргасан.

Төв банкны бодлого үйл ажиллагааг нийгэмд таниулах, мэдлэг мэдээллээр бүрэн хангахаар зорьж, тус бүр гурван сарын хугацаатай зорилтод аянуудыг зохион байгуулсан нь өндөр үр дүнд хүрлээ. Тухайлбал, “Мөнгөн тэмдэгтийн зохистой хэрэглээ” аянаар Монголбанкинд ирэх муу мөнгөн тэмдэгтийн тоо багассан, “Монгол алт” аянаар Монголбанкны алт худалдан авалт нэмэгдэж түүхэн үзүүлэлт болох 20.0 тоннд хүрсэн, “Санхүүгийн боловсрол” аянаар иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдэж, хуримтлалын ач холбогдлыг ойлгосон.

15. Монголбанкны судалгааны ажлууд бүхэлдээ эдийн засгийн өмнө тулгарсан сорилтуудыг даван туулахад чиглэгдэв.


Макро эдийн засгийн төсөөлөл, бодлогын шинжилгээний системийг цогц байдлаар хөгжүүлж, холбогдох загварчлалуудыг боловсронгуй болгосны дээр судалгаа, шинжилгээг эдийн засгийн өмнө тулгарсан сорилтуудыг шийдвэрлэх бодлогын хувилбаруудыг боловсруулахад чиглүүлэв. Тухайлбал, макро үзүүлэлтүүдийн богино хугацааны төсөөлөлд ашиглагддаг загваруудын алдааны шинжилгээг хийж, шинэчлэн сайжруулснаар төсөөллийн алдаа буурч, бодит өгөгдлийг тайлбарлах чадамж сайжрав. Богино хугацааны төсөөлөл гүйцэтгэх том хэмжээний тоон өгөгдөл ашиглах, хүчин зүйлсийн орчин үеийн төсөөлөл гаргах загварууд (FAVAR, 3PRF, MIDAS)-ыг шинээр нэвтрүүлэн ашиглаж эхлээд байна. Үүний зэрэгцээ инфляцийн талаарх иргэдийн болон аж ахуй нэгжүүдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “CAPI” системд суурилан хийдэг болов.

16. Монгол Улсын зээлжих зэрэглэлийг Фитч агентлаг “В-”, “тогтвортой” төлөвийг дээшлүүлэн “эерэг” хэмээн үнэлэв.

ОУВС-гийн Монгол Улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд олон талт болон хоёр талт санхүүгийн эх үүсвэр татах нөхцөл бүрдсэнтэй холбогдуулан Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 11 дүгээр сарын 17-ны өдөр зэрэглэлийг “В-” хэвээр, төлөвийг “Тогтвортой”-оос “Эерэг” болгон сайжруулан үнэллээ. Зээлжих зэрэглэлийн төлөв нь зэрэглэлийн цаашдын хандлагыг илтгэдэг бөгөөд “эерэг” төлөв нь зэрэглэл цаашид сайжрах боломжтойг илтгэж байна. Зээлжих зэрэглэлийн агентлагууд Монгол Улсын эдийн засгийг богино хугацаанд эрсдэл, сорилттой тулгарч буй боловч ирэх жилүүдэд ОУВС-гийн хөтөлбөр болон уул уурхайн томоохон төсөл хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэнээр эдийн засаг сэргэх, улсын төсөв, гадаад төлбөрийн чадвар огцом сайжрах хүлээлттэй байгаа тул Монгол Улсын дунд болон урт хугацааны эдийн засгийн төлөвийг эерэгээр үнэлсэн хэвээр байна.

17. 2017 оныг Монголбанкны орон нутгийн хэлтэс, салбарыг бэхжүүлэх жил болгон зарласнаар 21 аймаг, 4 бүсэд ажиллаж, мөнгөний бодлогыг хөдөө, орон нутгийн иргэдэд сурталчилдаг боллоо

Монголбанк 2017 оныг орон нутаг дахь хэлтэс, салбарыг бэхжүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах жил болгон зарлаж, бүсчилсэн болон хэсэгчилсэн сургалтуудыг зохион байгууллаа. Энэ хүрээнд “Монголбанкны удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг бүс нутаг бүрт хийж, Монголбанкны Ерөнхийлөгчөөр ахлуулсан удирдлагууд оролцов. Мөн жилийн хүрээнд орон нутгийн иргэд, дунд сургуулийн сурагчид, орон нутаг дахь төрийн байгууллагууд болон арилжааны банкуудын салбарын ажилтнуудад зориулсан сургалт, уулзалтуудыг зохион байгуулж, эх орны 21 аймагт хүрч, ажиллалаа. Үүгээр Монголбанк анх удаа орон нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулаад зогсохгүй нийслэлийн 6 дүүргийн ерөнхий боловсролын болон их дээд сургуулиудын сурагч, оюутнуудад төв банкны үйл ажиллагаа, Төрийн мөнгөний бодлогын тухай сургалт, уулзалтуудыг зохион байгуулсан ба цаашид уламжлалт ажил болгохоор зорьж байна.



**МОНГОЛБАНКНЫ ТЭРГҮҮН ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ О.ЭРДЭМБИЛЭГ**

БОЛОВСРОЛ, МЭРГЭЖИЛ:

1995: МУИС, Математикийн факультет, Хэрэглээний математик

1997: Шихихутуг Хууль зүйн Дээд сургууль

1998: МУИС, Эдийн засгийн сургууль, Бакалавр, Санхүү эдийн засаг

2002: Австрали Улсын Их сургууль, Кроуфордын төр, эдийн засгийн сургууль, Магистр, Хөгжлийн эдийн засаг

АЖЛЫН ТУРШЛАГА

1998–2007: Монгол Улсын Сангийн яам, Газрын дарга, Хэлтсийн дарга, Мэргэжилтэн

2007–2013: АНУ, ОУВС, Ахлах улс хариуцсан эдийн засагч, Улс хариуцсан эдийн засагч

2013–2014: Ньюком групп, Зөвлөх

2014: “ОЭКГ” ХХК, Гүйцэтгэх захирал

2014–2016: Голомт банк, Тэргүүн дэд захирал,

ТУЗ-ийн даргын Зөвлөх

2016: Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч

О.ЭРДЭМБИЛЭГ: БОДЛОГЫН ХУВЬД ТУУШТАЙ ЯВСНЫ ҮР ДҮНД СОРИЛТ ИХТЭЙ ЖИЛИЙГ АМЖИЛТТАЙ ДАВАН ТУУЛЛАА

Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэгтэй ярилцлаа.

–2017 он эдийн засгийн нөхцөл байдлыг тогтворжуулж, өсөлтийн эхлэлийг тавьсан жил боллоо гэж албаны хүмүүс дүгнэж байгаа. Монголбанк ч бас үүнтэй санал нийлэх байх. Гэвч цаашдаа эдийн засгийн өсөлтөө тогтворжуулахын тулд бодлогын шинэчлэл, реформуудаа тууштай үргэлжлүүлэх хэрэгтэй гэдгийг олон улсын байгууллагууд сануулж байна. Цаашдаа эдийн засгийг тогтвортой өсгөхөд Төв банкны бодлого ч бас чухал нөлөөтэй гэдэг нь тодорхой. Тэгэхээр 2018 онд олон нийт, Монголын нийгэм, эдийн засаг Төв банкны бодлогоос юу хүлээж болох вэ?

–Бодлогын хувьд зорилготой, тууштай явсны үр дүнд сорилт ихтэй жилийг амжилттай үдэж, 2018 оны гарааг сайн тавьж өглөө. Мөн 2017 оны хувьд зөвхөн тулгамдсан асуудлуудыг шийдээд зогсохгүй дунд, урт хугацаандаа үр нөлөөгөө өгөх бүтцийн шинж чанартай бодлогын арга хэмжээнүүдийг авснаараа онцлогтой жил боллоо. Цаашдаа бодлогын чиглэлээ өөрчлөхгүй харин зорилго, зорилтоо өндөр тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллахаар зорьж байна. Үүнд, мэдээж хэрэг мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгагдсан банкуудын эрсдэл даах чадварыг сайжруулах, эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын аргачлалыг нэвтрүүлэх, шаардлага үүсвэл

дахин хөрөнгөжүүлэх зэрэг эдийн засгаа тогтвортой өсгөхөд чиглэсэн арга хэмжээнүүдийг шат дараатайгаар, төлөвлөгөөнийхөө дагуу цогцоор нь чанартай хийх ажил орно. Хөрөнгө оруулагч нар, олон улсын байгууллагууд гээд түншлэгч нарын маань хүсч байгаа зүйл бол энэ.

Үнэхээр хүнд жил байсан гэдгийг нотлох нэгэн үйл явдал бол өнгөрсөн онд манай улсын гадаад зах зээл дээрээс босгосон мөнгөний хоёр хэлцлийг “Файнэнс Эйжа” сэтгүүлээс “Шилдэг хэлцэл” мөн “Азийн Шилдэг мөнгө босголт”-оор шалгаруулсан. Энэ хоёр шагналыг өгөхийн тулд олон шалгуур үзүүлэлтүүдийг харгалзан үздэг. Гол шалгуур нь юу вэ гэхээр энэхүү гадаад зах зээл дээрээс босгосон мөнгө ямар асуудлыг, ямар хүндрэлийг шийдэж чадсан юм бэ гэдэгт байсан. Тиймээс тэд үзэхдээ “Монгол Улсын мөнгө босголт нь эдийн засгийн хамгийн хүнд нөхцөл байдлаас гаргаж чадсан мөнгө босголт боллоо” хэмээсэн учир хамгийн сайн шилдэг хэлцлээр шалгарсан гэсэн үг. Монголбанкны зүгээс Засгийн газарт маш хүнд хэцүү үеийг давж туулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллаж чадсан. Цаашид ч бидний хамтын ажиллагаа улам сайжирна гэдэгт эргэлзэхгүй байна.

–Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч банкны хяналт шалгалт, банкны секторын бодлогын асуудлуудаа хариуцдаг. Тэгэхээр та өнөөгийн Монгол

Улсын банкны системийн нөхцөл байдлыг хэрхэн дүгнэх вэ? 2018 он банкны секторт шинэчлэлийн жил болно гэх хүлээлт байна. Энэхүү шинэчлэл юунаас, хэрхэн эхлэх бол?

-Банк, санхүүгийн систем нь санхүүгийн зуучлалын үүрэг гүйцэтгэдгийн хувьд бодит салбарын нөхцөл байдлыг илэрхийлж, хамааралтай оршдог. Нэг ёсны толины тусгалтай адилтгаж болох юм. Банкны салбарын өнөөгийн байдлын хувьд эдийн засгийн голлох салбарууд, ялангуяа уул уурхай, барилгын салбарт банкуудаас олгосон зээлийн эргэн төлөлт удааширч, чанар муудсан дүр зураг ажиглагдаж байгаа. Тэгэхээр банкууд ийм эрсдэлээс хамгаалах хангалттай хэмжээний нөөц хөрөнгө, эрсдэлийн удирдлагын оновчтой аргачлалыг нэвтрүүлсэн, бэлтгэл сайтай байх шаардлагатай байгаа юм.

Монголбанкнаас банкны салбарын хууль эрх зүйн шинэчлэлтэй холбоотой дунд хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж байгаа. Энэ хөтөлбөрөөр банкны салбарт түгээмэл мөрдөгддөг нийт 11 хуулинд онцгой шаардлагатай нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулга боловсруулахаас гадна шинээр зохицуулах шаардлагатай харилцааг хуульчлах ажил бас хийгдэж байна. Түүнчлэн ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн хүрээнд хамтран хэрэгжүүлж байгаа банкны бүтцийн өөрчлөлт, тогтворжуулалтын үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлнэ.

-Банкны шинэчлэл гэхээр одоо УИХ-аар хэлэлцэгдэж байгаа "Банкны тухай хууль" болон Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн төслүүдийн талаар ярихгүй байж болохгүй байх. Хуулийн төслүүдийн гол концепцийг та тайлбарлахгүй юу?

-Банкны үйл ажиллагааг зохицуулж байгаа гол хуулиуд бол энэ хоёр хууль мөн. Төв банк /Монголбанк/-ны хуулинд оруулахаар боловсруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн төслийг багцлах юм бол зарчмын гурван зүйл байгаа юм. Нэгдүгээрт, Төв банкны мандат, хоёрдугаарт, Төв банкны засаглал, гуравдугаарт, Засгийн газартай харилцах харилцааг илүү нарийвчлан тусгасан бөгөөд бодлогын шийдвэр гаргахад нөлөөлдөг асуудлуудыг хөндсөнөөрөө онцлог гэж ойлгож болно. Тухайлбал, Монголбанкны үндсэн зорилтыг одоогийн хуульд заасан хоёрдмол утгатай байгаа тодорхойгүй байдлыг арилгаж ойлгомжтой байдлаар томъёолсон, Улсын Их Хурлаас томилогддог Мөнгөний бодлогын хороог бий болгож хамтын шийдвэр гаргадаг тэр процесс

руу шилжихээр тусгасан байгаа.

Банкны тухай хуульд орж буй өөрчлөлтийн хувьд хоёр зүйл байгаа. Нэгдүгээрт, өнгөрсөн хугацаанд банкны салбартай холбоотой хүндрэлийг шийдвэрлэхэд төрөөс гаргасан зардлыг ирээдүйд гаргахгүй байх, гарвал багаар гаргах тэр зохицуулалтуудыг оруулж өгсөн, хоёрдугаарт, банкуудад хийгддэг хяналт, шалгалтын үйл явцыг илүү тодорхой, ойлгомжтой болгож өгснөөрөө онцлог гэж хэлж болно. За тэгээд мэдээж хэрэг эдгээр шаардлагын хүрээнд дагаж өөрчлөгдөх ёстой зүйл, заалтуудад өөрчлөлт оруулсан байгаа. Тухайлбал, банкуудын ТУЗ, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг засаглалын нийтлэг зарчимтай нийцүүлэн тусгасан байх жишээтэй.

-Банкны хуулиар Монголбанкны хяналт шалгалтыг урьдчилсан байдлаар мөн явцын тайлан, үнэлгээнд суурилж, тухай бүрт нь арга хэмжээ авах эрхтэй байхаар зохицуулж байгаа. Ингэснээр хадгаламж эзэмшигчид, харилцагчдын мөнгийг хамгаалахад Төв банкны үүрэг, оролцоог нэмэгдүүлж өгч байгаа. Гэхдээ үүний нөгөө талд Төв банк эрх мэдлээ хэт их тэллээ гэх шүүмжлэл бас өрнөж байх шиг байна?

-Тантай санал нэг байна. Тийм зорилго агуулсан. Хуулийн төсөлд Монголбанкнаас авах арга хэмжээтэй холбоотой оруулсан зохицуулалтууд бол олон улсын болоод Монгол Улсад учирч байсан банкны салбарын хямрал, томоохон банкуудыг татан буулгахтай холбоотой татвар төлөгчдийн мөнгөөр гарсан ихээхэн хэмжээний зардлыг дахин гаргахгүй байх, системийн тогтвортой байдлыг тогтмол хангаж, эрсдэл нэмэгдэх шинж тэмдэг илэрсэн төдийд яаралтай арга хэмжээ авах боломжтой байхаар зохицуулахаар тусгасан гэсэн үг. Харин тэр нэмэгдэж байгаа эрх мэдэлтэй холбоотойгоор хязгаарлалтууд орж өгсөн. Хариу үйлдэлтэй функц байх ёстой гэдгийг бид ойлгож байгаа. Шийдвэр гаргах процесс, давхар хяналт, банкны хяналт, шалгалтын хороогоор хэлэлцэж, шийдвэр гаргах зарчим гээд өөрчлөлтүүдийг тусгаж өгсөн. Нөгөө талдаа банкны зүгээс үндэслэлгүй гэж үзсэн Монголбанкны аливаа шийдвэрийг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу гомдол гарган тухай бүр шийдвэрлүүлээд явах эрх нь бас байгааг хэлэх нь зүйтэй байх.

-Банк бол цэвэр итгэлцэл дээр тогтдог харилцаа. Энэ утгаараа хэдхэн эздийн эрх мэдлээр бус

харилцагчдын хөрөнгө оруулалттай үйл ажиллагаанд чиглэсэн байж болох уу?

-Үнэн. Энэ нь нэг талаас банкны зүгээс хийх сонголтын асуудал. Банкныг цөөн хүмүүс эзэмших үү эсвэл хувь эзэмшлээ тэлж олон нийтэд нээлттэй хүргэх үү гэсэн шийдвэрүүд тухайн банкны бизнес загвар, үйл ажиллагааны онцлог, цар хүрээ болон цаашид урт хугацаанд хэрэгжүүлэх стратегиас хамаарна. Шинээр өргөн баригдсан "Банкны тухай хууль"-ийн төсөлд хүндрэлд орсон банкны хувь эзэмшлийг олон улсад түгээмэл мөрдөгддөг практикийн дагуу томоохон харилцагчдад шилжүүлэх сонголттой байхаар тусгасан байгаа. Түүнээс гадна "Дахин хөрөнгөжүүлэлтийн тухай хууль"-ийн төслийг хэлэлцэх үеэр энэ сэдвийг хөндөж олон талаас нь, янз бүрийн түвшинд ярилцана гэж бодож байна.

-Чанаргүй зээлийн асуудлаар дараагийн сэдвээ үргэлжлүүлэе. Чанаргүй зээлийг бууруулахын тулд богино хугацааны арга хэмжээний эхлэл болгож банкны активын чанарын үнэлгээг хийж дуусгалаа шүү дээ. Ямар дүгнэлт гарсан бэ?

-Банкуудын актив хөрөнгийн чанарын үнэлгээний эцсийн үр дүн хараахан гарах болоогүй байгаа. Хөтөлбөрөөр тохирсон төлөвлөгөөний дагуу дөнгөж эхний арга хэмжээнүүд авагдаад явж байна. Та нар мэдэж байгаа шүү дээ, анхны үнэлгээ 2016 оны тайлан баланс дээр хийгдсэн гэж. Дараа нь 2017 оны 3 дугаар улирлаар тохируулга хийгдсэн. Одоо банкууд ирэх 3 жилийн бизнес төлөвлөгөөгөө гаргаж өгөхөөр ажиллаж байгаа. Тэр төлөвлөгөөн дээр стресс-тест хийгдэнэ. Тэрнээс өмнө стресс-тестийн суурь үзүүлэлтүүд дээрээ ОУВС-тай тохиролцох ёстой байгаа. Тэр бүгдийн дараа банкуудад хэрвээ өөрийн хөрөнгийн дутагдал үүсэхээр байвал хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх, эсвэл шинэ хөрөнгө оруулагч нарыг оруулж ирэх хугацаа өгнө. Тэр хугацаа одоогийн байдлаар ОУВС-тай тохирсноор бол 2018 оны 11 дүгээр сарын сүүл хүртэл өгөгдөхөөр байгаа. Би бол хувьдаа дэндүү богино хугацаа байна гэж үзэж байгаа. Тэрийгээ ч ОУВС-ийнханд хэлсэн. Энэ сарын сүүлээр ирэх ОУВС-ийн ажлын хэсгийн багийнхан тэр талаар ярилцана гээд бэлтгэлтэй ирж байгаа. Тодорхой болгох шаардлагатай зүйлс нэгээр тогтохгүй байна. Тийм болохоор ийм тийм гээд ямар нэгэн дүгнэлт өгөх бол эрт байна.

-“Актив удирдлагын компаний тухай хууль”-ийн төсөл боловсруулсан шүү дээ. Энэ хуулийн төслөөр төр чанаргүй зээлийг авах тухай тусгасан нь хэр оновчтой шийдэл вэ?

-Олон улсад янз бүрийн туршлага байна. Өмчлөлийн хэлбэрээс шалтгаалаад үр дүн нь бас өөр өөр байх жишээтэй. Бидний зүгээс урт хугацаанд үр дүнтэй, ашигтай ажиллах тэр хэлбэрийг эрэлхийлж байгаа. Энэ талаар ОУВС-гийн мэргэжилтнүүдтэй бас яриа хэлэлцээ хийгээд явж байна. Эхний ээлжинд санхүүгийн салбарт үүсэх хүндрэлээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд нэгдсэн бодлого хэрэгжүүлэгч байгууллага нь зохицуулаад явах нь хүндрэлээс сэргийлээд зогсохгүй, боломжит зардлын хэмжээг бууруулж, эдийн засгийн салбараа ч дэмжих нөлөө үзүүлнэ гэж харж байгаа.

-Зээлийн эрсдэлийн түвшинг салбарын шинэчлэлийн хүрээнд хэрхэн сайжруулахаар зорьж байна вэ?

-Түрүүн хэлсэн Актив удирдлагын компаний үйл ажиллагааг зохицуулахаас эхлээд шинэ Банкны тухай хуулийн төсөлд зээлийн эрсдэлийн түвшинд банкуудад тавигдах хязгаарлалтын хүрээг өргөтгөж, зээлийн ангилал, эрсдэлийн сан байгуулахад тавигдах шаардлагуудыг илүү уян хатан, эрсдэлд суурилсан шинж чанартай байдлаар тусгасан байгаа.

-Ярилцлагынхаа төгсгөлд сонирхоход манай улсын банк санхүүгийн салбарын тогтвортой найдвартай ажиллагааны төлөө Монголбанкнаас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүд олон улсын стандартаас илүүтэй өөрийн орны эдийн засгийн онцлог, нөхцөл байдалтай хэрхэн уялдахаар байгаа вэ?

-Аль аль нь чухал. Бидний зүгээс аливаа бодлогын арга хэмжээг боловсруулах, гүйцэтгэхэд тухайн шийдвэр шууд нөлөөлөхөөр байгаа бүлгүүдийн санал бодлыг байнга сонсч хүлээн авахыг чухалчлан үзэж байгаа. Тиймээс олон улсад нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг Монголын санхүүгийн салбарын онцлогт хэрхэн нийцүүлэх, хоорондын ялгааг нь бууруулах талаас бодлогын байр сууриа чиглүүлэх нь зүйтэй байгаа учраас бидний зүгээс онцгой анхааран ажиллаж байна.

Ярилцсанд баярлалаа.



Активын Чанарын Үнэлгээ (АЧҮ)

Монгол Улс ОУВС-ийн "Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр"-т хамрагдах үед тавигдсан шаардлагуудын дагуу эдийн засгийг сэргээхийн тулд банкны тогтолцоонд активын чанарын үнэлгээ хийв.



Сонгон шалгаруулалтаар Pricewaterhouse Coopers компанийн Чех Улс дахь салбар шалгарч үнэлгээг хийсэн.



Европын төв банкны (ЕТБ) Активын чанарын үнэлгээний аргачлалыг ашигласан.



ЕТБ-ны аргачлалыг ашигласан ч Монгол Улсын хууль, Монголбанкны журмуудтай нийцтэй болгож өөрчилсөн.




Мал, уул уурхайн тусгай зөвшөөрөл зэрэг бүхий л зүйлийг зээлийн барьцаанд тооцож үнэлгээг хийсэн.

Европын Төв банк нь гишүүн орнуудын банкны системийн нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоонд шилжих зорилгоор 2013-2014 онуудад АЧҮ хийсэн.

19	Хамрагдсан улсын тоо	6000+	Үнэлгээ хийсэн нийт ажилтны тоо
130	Банкны тоо	800	Үнэлгээ хийсэн зээлийн багцын тоо
81.6%	$\frac{\text{Үнэлгээ хийсэн актив}}{\text{Нийт актив}}$ харьцаа		Үнэлгээ хийсэн зээлдэгчдийн тоо
170k	Үнэлсэн барьцаа хөрөнгийн тоо		

Активын чанарын үнэлгээг схемээр харуулбал:





Активын Чанарын Үнэлгээ (АЧҮ)

Хийгдэх ерөнхий схем



Өөрийн хөрөнгийн бүтэц

Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгө болон гадны эх үүсвэрээр хөрөнгөө бүрдүүлж, зээл гаргадаг. Хүүний орлого ашгийг нэмэгдүүлдэг бол эрсдэлийн сангийн зардал **ашгийг бууруулна**.



Зээлийн эрсдэлийн сан

Зээлийн эрсдэлийн сан нь банкны өөрийн хөрөнгөд нөлөөлдөг гол үзүүлэлт. Хэрэв олгосон зээл төлөгдөхгүй бол хадгаламж эзэмшигчийн мөнгийг **хамгаалахын** тулд эрсдэлийн зардал тооцно.



1 Олгосон зээлийг хянах

Зээлдэгчийн санхүүгийн байдал, орлогын түвшин, **зээл төлөх чадвар** зэргийг үнэлнэ. Зээлийг төлөх хэмжээний орлого хангалттай байгаа эсэх.



Арга хэмжээ авахгүй

Хэрэв зээлдэгчийн санхүүгийн байдал эсвэл барьцаа хөрөнгийн үнэлгээ зээлийг төлж чадахуйц, цаашлаад банкны өөрийн хөрөнгийн харьцаа Монголбанкны шалгуурыг хангаж байвал арга хэмжээ авахгүй

Тийм



4

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

Банкны өөрийн хөрөнгийн түвшин буурах үед **Монголбанкны шалгуурыг** хангаж буй эсэх.

Үгүй



7 Банк тогтворжих

Банкны үйл ажиллагаа хэвийн болсноор төр хөрөнгөө буцаан татаж, банкыг **хувийн хэвшилд** шилжүүлнэ.



6 Төрийн оролцоо

Зайлшгүй тохиолдолд банкуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх ажлыг төрийн оролцоотой хийж болно.

5

Банкийг дахин хөрөнгөжүүлэх

Хэрэв банкны өөрийн хөрөнгө шаардлага хангахгүй бол **6 сарын хугацаатайгаар** банкуудыг өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхийг шаардна.

2

Барьцаа хөрөнгийн үнэлгээг хийнэ

Барьцаа хөрөнгийн **үнэлгээний** үр дүнд зээл нөхөн төлөхөд хангалттай эсэхийг шалгана.

Үгүй



3

Эрсдэлийн сан байгуулах

Барьцаа хөрөнгийн үнэлгээ - Нийт зээлийн дүн = Эрсдэлийн сангийн зардал. Эрсдэлийн санг байгуулснаар банкны ашиг буурч цаашлаад банкны **өөрийн хөрөнгийн түвшин** буурах боломжтой

АКТИВЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР ТАНЫ МЭДЭХ ЗҮЙЛС

Өөрийн хөрөнгийн үнэлгээний тохируулгаас гарах үр дүн ямар ач холбогдолтой вэ, үр дүн нь юуг илэрхийлэх вэ?

Активын чанарын үнэлгээний өөрийн хөрөнгийн тохируулгаас гарах үр дүнд тухайн банк гадны шокуудын нөлөөнд (эдийн засгийн нөхцөл байдал, дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлт, ажилгүйдлийн түвшин) үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжтой эсэх, өөрийн хөрөнгийн зохистой шалгуур үзүүлэлтийг хангах боломжтой эсэхийг тодорхойлох юм. Өөрөөр хэлбэл, макро эдийн засгийн үзүүлэлтүүд дордвол, эсвэл дээрдвэл тухайн банк ямар байдалд орох вэ гэдгийг тодорхойлно.

Өөрийн хөрөнгийн үнэлгээний тохируулгын үр дүн банкуудын зээлийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх вэ?

Өөрийн хөрөнгийн тохируулгын үр дүнд банкуудад нэмэгдүүлэх шаардлагатай өөрийн хөрөнгийн хэмжээг урьдчилсан байдлаар гаргаснаар, банкны зээлийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө. Олон улсын хөндлөнгийн компаниар активын чанарын үнэлгээ хийлгэх нь гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, гадны зах зээлээс хөрөнгө татах боломжийг олгохын зэрэгцээ банкны системийг “эрүүлжүүлнэ”. Үүний үр дүнд банкуудын зээлийн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэх, нийт эдийн засгийн секторын зээлийн өртөг буурах ач холбогдолтой.

Активын чанарын үнэлгээ дууссаны дараа банкуудад “юу тохиолдох” вэ?

Банкны активын чанарын үнэлгээгээр Монгол Улсын банкны систем банкуудад шаардагдах хөрөнгийн хэрэгцээг харуулна. Банкинд өөрийн хөрөнгийн дутагдал үүсэхээр байгаа бол банк өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон бусад санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулах, өөрийн хөрөнгийн шаардлагыг хангахуйц хэмжээнд нэмэгдүүлэх төлөвлөгөөг боловсруулж, урт хугацаанд үр ашигтай байдлаар хэрэгжүүлэх, тэдний тогтвортой байдлыг бэхжүүлэх хугацаатай ажлын төлөвлөгөө, түүний биелэлтийг тогтмол хянах боломжтой байхаар боловсруулж Монголбанкнд ирүүлнэ.

Активын чанарын үнэлгээний үр дүнд банк өөрийн хөрөнгийн дутагдалд орвол банк “хаалгаа барих” шалтгаан болох уу?

Активын чанарын үнэлгээ болон өөрийн хөрөнгийн тохируулгын үр дүнд өөрийн хөрөнгийн үзүүлэлт нь хангалттай гэж үнэлэгдсэн, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагагүй банкууд тодорхой болно. Харин өөрийн хөрөнгийн дутагдалд орсон банкууд өөрийн хөрөнгийг шаардлагатай түвшинд нэмэгдүүлэх, бүтцийн өөрчлөлт хийх зэрэг арга хэмжээг авч ажиллана. Тодруулбал, банкны хувьцаа эзэмшигчид өөрсдийн нөөц бололцоогоор банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, эсвэл шаардлага хангасан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад банкны хувьцааг эзэмшүүлэх боломжтой юм.

Монгол Улс банкны системд бүтцийн өөрчлөлтийг хэрхэн хийж байсан бэ?

Монголбанкнаас банкуудад бүтцийн өөрчлөлт хийх

хөтөлбөрийг боловсруулан тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байсан. Жишээ нь, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийг баталж, улмаар Банкны тухай хуулийг шинэчлэн найруулж, Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, салбарын хууль зүйн орчныг сайжруулсан. Монголбанк нь өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллахгүй байгаа банкуудад бодитой, шинэ эх үүсвэрээр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх замаар хуульд заасан доод хэмжээнд хүргэх шаардлага тавьж, хангуулах зорилготой байсан. Хэрэв банк тогтоосон хугацаанд хувийн хөрөнгө оруулалтаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлж чадахгүй бол Монгол Улсын Засгийн газар эцсийн зээлдүүлэгчийн хувьд Монголбанкны оролцоотойгоор банкийг түр “хугацаагаар дахин хөрөнгөжүүлэх” арга хэмжээ авсан. Дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээ нь түр зуурын дэмжлэг байсан бөгөөд Засгийн газар оруулсан хөрөнгө оруулалтаа банкны хөрөнгөөр эргүүлэн төлүүлэх баталгааг хангасан.

Активын чанарын үнэлгээний үр дүнд хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт орох уу?

Хууль эрх зүйн орчин нь нийгмийн хөгжилтэй нийцэж байх нь зүйтэй юм. Санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой байдлыг хангахын тулд хуулийг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар хөгжлийн тогтвортой байдлыг хангадаг. Активын чанарын үр дүнд дараах хууль, журмуудад өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Үүнд:

- Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Монголбанкны Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам болон барьцаа хөрөнгийг үнэлэх аргачлалыг олон улсын стандарт, шилдэг туршлагад нийцүүлэн хэрэгжүүлнэ;
- Банкны засаглалыг сайжруулах хүрээнд холбогдох журамд өөрчлөлт орно;
- Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт тогтоох, түүнийг хянахтай холбоотой журамд өөрчлөлт орно.

Барьцаа хөрөнгийн үнэлгээ хангалтгүй бол яах вэ?

Активын чанарын үнэлгээний явцад зээлийн хувийн

хэргийг шалгахад зээлдэгчийн мөнгөн урсгалыг тооцох ба тухайн зээлдэгч нь ирээдүйн мөнгөн урсгалаас орж ирэх орлогоор авсан зээлээ бүрэн төлж чадхааргүй бол барьцаа хөрөнгийн үнэлгээг хийнэ. Зээлийн эрсдэлийн санг барьцаа хөрөнгийн үнэлгээг хангалтгүй дүнгээр байгуулна.

Бүлгийн үнэлгээг хэрхэн хийх вэ?

Зээлийн үнэ цэнийн бууралтыг тооцоолох зорилгоор бүх төрлийн зээлийг хоёр бүлэгт хуваана. Үүнд:

- Тусгайлан авч үзэх зээл
- Бүлгээр авч үзэх зээл

Банк тусгайлан болон бүлгээр авч үзэх зээлийг тодорхойлох бодлогыг дотооддоо боловсруулж, мөрдөнө. Тусгайлан авч үзэх зээл гэж үнэ цэнэ нь буурсан тохиолдолд банкны зээлийн багцын чанар болон цэвэр ашигт мэдэгдэхүйц нөлөөлдөг зээлийг ойлгоно. Банк хоёр шалтгааны улмаас зээлийн эрсдэлийн санг тооцохдоо зээлийг бүлэглэх шаардлагатай болдог: i) зээлийн багцад багтсан бүх зардлыг мэдэх боломжгүй (мэдээлэлд харгалзах цаг хугацаанаас шалтгаалан) ii) зээл тус бүрийн үнэ цэнийн бууралтыг бодитойгоор тусгайлсан үнэлгээний аргаар тооцоолох боломжгүй (ажилтан/нөөц/мэдээлэл дутагдсанаас шалтгаалан). Банк түүхэн болон статистикийн загварыг ашиглан зээлийг бүлэглэн тооцож нийт зээлийн эрсдэлийн санг тогтооно.

Гуравдугаар түвшний актив хөрөнгө гэж юу вэ?

Гуравдугаар түвшний актив хөрөнгөд банкны эзэмшиж буй зээлээс бусад үнэт цаас, үндсэн хөрөнгө болон бусад хөрөнгүүд хамаарч байгаа бөгөөд активын чанарын үнэлгээний ажлаар том нөлөө үзүүлэхээр хөрөнгүүдэд хөндлөнгийн хараат бус үнэлгээ хийгдэнэ.

Банкны системд нөлөө бүхий банкууд болон дунд, жижиг банкуудад активын чанарын үнэлгээ хийхэд ямар ялгаа гарах вэ?

Активын чанарын үнэлгээний ажлаар бүх банкуудад ижил аргачлалаар үнэлгээ хийх тул ялгаа гарахгүй. Харин банк тус бүр өөрийн зээлийн бодлого, дүрэм, журмаа мөрдөн ажилладаг тул эрсдэл даах чадвар өөр өөр байж болох юм.

Улаанбаатар хотын инфляци 11 дүгээр сарын байдлаар

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляци **2017 оны 11 дүгээр сард** улсын хэмжээнд **6.5%-д**, Улаанбаатар хотын хэмжээнд **7.6%-д** хүрлээ.



Инфляци, түүний бүрэлдэхүүн



ТОГТВОРЖИЛТ, ӨСӨЛТИЙН ЗҮГТ



Эдийн засгийн ухааны доктор, профессор
Надмидын БАЯРТСАЙХАН

Энэхүү нийтлэлээр Монголбанкны мөнгөний бодлогын 2017 оны хэрэгжилт, 2018 оны зорилт, хэрэгжүүлэх стратеги, Монгол улсын эдийн засагт тулгарсан хүндрэлийн шалтгаан, хүндрэлийг давах зорилгоор хэрэгжүүлсэн бодлогын сонголтын талаар байр сууриа илэрхийлж байгаа болно.

Эдийн засагт ямар нөхцөл үүсээд байсан бэ?

Монголбанкинд 2017 онд тулгарсан сорилт, түүнтэй уялдсан бодлогын зорилт нь макро эдийн засгийг тогтворжуулах явдал байлаа. Дэлхийн зах зээл дээрх экспортын бүтээгдэхүүний үнийн бууралт, хэт тэлэх бодлогын нөлөөгөөр эдийн засагт дотоод, гадаад санхүүжилтийн хүндрэл үүссэн байв. Макро бодлого нь мөчлөг сөрсөн арга хэмжээ байсан боловч уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлийн бүтэн мөчлөгийг давж, тогтвортой үргэлжлэхээргүй, эдийн засгийн бодит санхүүгийн нөөц чадавхиас хэт давуулсан нь цаашид төсөв, мөнгөний бодлогыг зөөлрүүлэх орон зайг шавхсан юм.

Төсвийн бодлого өнгөрсөн 4-5 жилд тасралтгүй өндөр алдагдалтай хэрэгжсэн нь улсын төсвийг санхүүжилтийн хомсдолд оруулж, төсвийн бодлогын тогтвортой байдал алдагдах эрсдэлийг бий болгосон. Төсвийн нийт санхүүжилтийн дутагдал 2016 оны байдлаар 5.7 их наяд төгрөгт хүрээд байсан. Үүнээс өнгөрсөн хугацааны төсвийн өндөр алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гадаад, дотоод зах зээлээс авсан өрийг эргэн төлөхөд 2.0 их наяд, 2016 оны төсвийн алдагдлыг нөхөхөд 3.7 их наяд төгрөг, алдагдлыг санхүүжүүлсэн өрийн хүүний зардал 1.0 их наяд төгрөг буюу 2016 оны төсвийн орлогын 16.9 хувьтай тэнцэх төвшинд ирэв. Мөн 2012 оны эцэст 3.9 их наяд орчим төгрөг буюу ДНБ-ий 29%-тай тэнцэж байсан Засгийн газрын өрийн хэмжээ 2016 оны эцэст 22.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 93%-д хүрч нэмэгдэн өрийн тогтвортой байдал алдагдах эрсдэл үүсэв. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх Засгийн газрын бондын хүү дотоод зах дээр 17%, гадаад зах зээл дээр 10-11%-д хүрч эхлэв. Мөн Монгол улсын Засгийн газарт гадаад бондуудыг эргэн төлөхөд шаардлагатай төсвийн

санхүүгийн нөөц, гадаад валютын бэлэн эх үүсвэр байгаагүй, түүнийг гадаад зах зээл дээрээс босгох боломж маш хязгаарлагдмал болоод байлаа.

Төсвийн хүндрэлтэй байдал нь төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй хосолж гадаад төлбөр тооцооны эх үүсвэрийн дутагдал үүссэн нь эдийн засгийн гадаад санхүүжилтийн дутагдлыг бий болгосон юм. Өнгөрсөн оны эцсийн байдлаар 2017-2018 онд эргэн төлөгдөх төлбөрийг барагдуулахад Монгол улсын гадаад валютын бэлэн нөөцийн хэмжээ хангалтгүй байсан. Монгол улсын гадаад валютын нийт нөөц 2016 оны эцэст 1.3 тэрбум ам.доллар байсан бол ойрын ирээдүйд Засгийн газар, Монголбанкны эргүүлэн төлөх гадаад өрийн хэмжээ 2.8 тэрбум ам.доллар (хувийн секторын өрийн эргэн төлөлтийг оруулалгүйгээр) байсан. Хөгжлийн банкны 2012 онд авсан 580 сая ам.долларыг 2017 оны 3 дугаар сард, Хятадын ардын банкнаас 2013 оноос своп хэлцлээр авсан 12 тэрбум юань (тухайн үеийн ханшаар 1.7 тэрбум ам.доллар)-ыг 2017 оны 8 дугаар сард, Монгол улсын ЗГ-ын 2012 онд босгосон Чингис бондоос 500 сая ам.долларын эргэн төлөлт 2018 оны 1 дүгээр сард, 2015 онд босгосон 156 сая ам.доллартай тэнцэх Димсам бондын эргэн төлөлт 2018 оны 6 дугаар сард тус тус эргэн төлөгдөхөөр хүлээгдэж байлаа.

Монгол улсын зээлжих зэрэглэл буурсан, Монгол улсын нэр хүнд олон улсын санхүүгийн зах зээл, олон улсын санхүүгийн байгууллагуудын хүрээнд ихээр унасан нь гадаад өрийн эргэн төлөлтийг дотоод зах зээлд сөрөг нөлөөгүйгээр шийдвэрлэхэд хүндрэл учруулж эхлэв. Монгол улсын зээлжих зэрэглэлийг Мүүдис агентлаг 2014 оноос эхлэн 3 удаа (B1-Сaa1), Фийтч агентлаг 2015 оноос 2 удаа ((B+)-(B-)), Стандарт энд Фүүрс агентлаг 2014 оноос 3 удаа ((BB-)-(B-)) буулгаад байсан. Энэ нь Монгол улсын бондын эрэлтийг бууруулан хүүг нэмэгдүүлж, гадаад зах зээл дээрээс ЗГ болон хувийн секторын аль аль нь эх үүсвэр босгоход сөргөөр нөлөөлөв. Зээлжих зэрэглэл буурахын зэрэгцээ олон улсын санхүүгийн байгууллагууд болон зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудын анхааруулга, бодлогын зөвлөмжийг үл ойшоож ирсэн нь Монгол улсад итгэх итгэлийг улам дордуулаад байлаа.

Эдийн засагт үүсээд байсан энэхүү нөхцөл байдал нь зах зээлийн ирээдүйн төлөвийн талаарх тодорхой бус байдал эрс нэмэгдэхэд нөлөөлж, дотоод зах зээл дээр оролцогчид болох бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч, хадгаламж эзэмшигч, хэрэглэгчдийн итгэл буурч, эдийн

засаг, бизнесийн үйл ажиллагаа, түүнтэй холбоотой хэлцлүүд зогсонги байдалд ороход нөлөөлсөн. Нийт хөрөнгө оруулалт 2014-2015 онд 8 улирал дараалан, өрхийн хэрэглээний зардал 4 улирал дараалан тус тус агшиж, эдийн засгийн өсөлт 2016 оны 3 дугаар улирлын байдлаар сөрөг төвшинд, валютын ханш 2016 оны 8 дугаар сарын байдлаар сүүлийн 60 сарын хугацаанд нийт 76.7%-иар суларч, мөнгөний нийлүүлэлт (2016 оны 2 дугаар сарын байдлаар) болон зээлийн үлдэгдэл (2016 оны 5 дугаар сарын байдлаар) сүүлийн 1 жилийн турш өмнөх жилийн төвшнээсээ агшаад байсан.

Ямар бодлого хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрээд байна вэ?

Энэхүү нөхцөл байдалд Монголын төрөөс гадаад санхүүжилтийн дарамтыг дотоод эдийн засаг, санхүүгийн зах зээлд сөрөг нөлөөгүйгээр шийдвэрлэх, ханшийн хэт үнэлэгдсэн байдлыг залруулах, бодлогын хараат бус байдлыг хангах, олон төсвийг нэгтгэж, нэгдмэл байдлыг хангах, олон улсын санхүүгийн байгууллагууд, зээлжих зэрэглэлийн агентлагуудын Монгол улсад итгэх итгэлийг сэргээх, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэхээр зоримог үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм. Олон улсын санхүүгийн байгууллагууд болон зээлжих зэрэглэл тогтоогч агентлагуудаас Монголд итгэх итгэлийг сэргээж чадлаа. Бодлогын хараат бус байдлыг нэмэгдүүлж, бодлогыг харьцангуй урт хугацаагаар төлөвлөн макро эдийн засгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хадгалахад чиглэсэн байдлаар хэрэгжүүлэх нь чухал байсан юм. Энэ зорилгын хүрээнд Монголбанк төсвийн шинж чанартай хөтөлбөрүүдийг зогсоож, инфляцийг тогтворжуулах үндсэн зорилгоо чухалчилж бодлогын шийдвэрүүдээ гаргах амлалт өгч, түүнийгээ биелүүлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл, Монгол улсын зээлжих зэрэглэлийн төлөв сайжрахад эергээр нөлөөлсөн. 2017 оны 11 дүгээр сарын байдлаар Фитч агентлаг Монгол улсын зээлжих зэрэглэлийн төлөвийг "тогтвортой"-оос "эерэг" болгож дээшлүүлээд байна.

Гадаад өрийн эргэн төлөлтийг дотоод зах зээлд дарамтгүйгээр шийдвэрлэж чадлаа. Гадаад валютын нөөц хүрэлцээгүй байсан тул гадаад өрийн эргэн төлбөрийн хугацааг нь сунгахаас өөр бодлогын сонголт бидэнд байгаагүй. Монгол улсын 2016 оны сүүлийн хагаст гадаад зах зээл дээр бонд гаргах эхний оролдлогууд амжилтгүй болсон хэдий ч Хөгжлийн банк, Чингис бонд, Дим сам бондын дахин

санхүүжилтийн асуудлыг 2017 онд шийдвэрлэж чадлаа. Мөн Монголбанкны зүгээс Хятадын ардын банкнаас своп хэлцлээр авсан зээлийн хугацааг сунгах ажил хэд хэдэн хэлэлцээрийг дамнан байж 2020 он хүртэл сунгаж 12 тэрбум юаний буюу тухайн үеийн ханшаар 1.7 тэрбум ам.долларын эргэн төлөлтийг хойшлуулж, төлбөрийн тэнцлийн богино хугацааны хамгийн том төлбөрийг шийдвэрлэсэн нь эдийн засаг, зах зээл тогтворжиход маш том хувь нэмэр болов. Эдгээр өрийн эргэн төлөлтийн дүн 2.8 тэрбум ам.доллар боловч дефолт хийсэн тохиолдолд хугацаанаасаа өмнө нэмж дуудагдах зөвхөн улсын секторын өрийн хэмжээ 900 орчим сая ам.доллар байсан. Дээр нь хувийн сектороос эргэн дуудагдах дүнг нэмж үзвэл Монгол улсын хөгжил даруй 10 орчим жилээр эргэж хойш шидэгдэх нөхцөл үүсээд байлаа.

Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж эхэллээ. Хөтөлбөр хэрэгжүүлэх эсэх нь эргэлзээтэй байсан үед Олон улсын валютын сантай хэлэлцээр хийж эцэст нь Монгол улсад хөтөлбөр хэрэгжүүлэх шийдвэрийг гаргууллаа. ОУВС-гийн хөтөлбөр хэрэгжихгүй тохиолдолд бусад олон улсын санхүүгийн байгууллага, донор орнуудтай хамтарсан хөтөлбөрүүд хэрэгжихгүй юм. Монгол улс болон ОУВС 5 тэрбум гаруй ам.долларын санхүүжилттэй өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлэхээр тохиролцоонд хүрснээр Монгол улсад ойрын 3 жилд шаардлагатай байсан санхүүжилтийн хомсдолоо шийдвэрлэсэн. Мөн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Жайка зэрэг олон улсын санхүүгийн байгууллагад, Япон, Солонгос, Хятад, Европын холбоо зэрэг хандивлагч улстай хамтарсан хөтөлбөрүүд хэрэгжүүлэхээр болсон. Эдгээр хөтөлбөр хэрэгжихээр болсон нь өрийн эргэн төлөлтийн хугацааг сунгах, шинээр бонд босгох, төсөв, мөнгөний бодлогын хараат бус байдлыг сайжруулах, санхүүгийн зах зээлийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, олон улсын санхүүгийн зах зээл дээр Монгол улсын алдагдсан нэр хүндийг эргүүлэн сэргээхэд том хувь нэмэр болж байна. Энэ нь гадаад зах зээл дээр 2017 оны 10 дугаар сард шинээр босгосон ЗГ-ын бондын хүү 2 дахин буурсан, зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд зээлжих зэрэглэлийн төлөвийг эерэг болгож сайжруулж байгаагаас харагдана.

Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх төвшинд гарч буй өөрчлөлтүүд, түүнийг даган зээлжих зэрэглэл сайжрах нь цаашид улам чухал болох бөгөөд үүний

давуу талыг олон улсын санхүүгийн зах зээл дээрээс эх үүсвэр босгож, төсөл хэрэгжүүлэх бизнес эрхлэгчид, тэдгээрийн амжилттай төслийн үр дүнгээр бий болох ажлын байр, орлогын өсөлтөөр дамжуулан иргэд хүртэх болно.

Эдийн засгийн гадаад тал дээр, төлбөрийн тэнцэл дээр эерэг өөрчлөлт гарахын зэрэгцээ дотоод зах зээлд оролцогчдын итгэл сэргэж байна. Богино хугацааны нөлөөг харахаас илүүтэй дунд, урт хугацааны тогтвортой өсөлтийг эрхэмлэж, зорьсон бодлого, түүний нээлттэй ил тод байдал нь бизнес эрхлэгч, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдийн итгэл сэргэж, хэлцлийн хугацааг уртасгахад эергээр нөлөөлж байна. Энэ нь зээлийн өсөлтийн сэргэлт, ажил эрхлэлтийн өсөлт, хэрэглэгчийн болон менежерүүдийн итгэл сэргэж байгааг илтгэсэн статистик мэдээллүүдээс харагдаж байна. NRCC компаний хэрэглэгчийн итгэлийн индексийн тайлангаас харахад 2016 оны 2 дугаар улирлаас хойш тасралтгүй буурч байсан ирээдүйн итгэлийн индекс 2017 оны 3 дугаар улиралд анх удаа сайжирсан бөгөөд ажлын олдоц болон орлого сайжирна гэсэн итгэл сэргэсэн нь үүнд нөлөөлжээ. Мөн экспортын бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр төвшинд тогтвортой байгаатай давхцан ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хүрээнд тохирсон бодлогын зорилтот арга хэмжээнүүд амжилттай хэрэгжиж, гадаад валютын нөөц нэмэгдэж байгаа нь валютын ханшийн хүлээлт тогтворжиход таатай нөлөө үзүүлж байна. Монгол улсын гадаад валютын нийт нөөцийн хэмжээ оны эхнээс 1 тэрбум гаруй ам.доллараар нэмэгдэж, 2.5 тэрбум ам.доллар давж, Монголбанкны гадаад валютын нээлттэй цэвэр позици 900 гаруй сая ам.доллараар сайжраад байна.

Валютын нөөц нэмэгдэж, өрийн эргэн төлөлтийн хугацаа хойшилж байгаа үед төгрөгийн ханш харьцангуй сул төвшинд хэвээр байгаа ч энэ нь импорттой өрсөлдөх (хөнгөн хүнс, оёмол, сүлжмэл гэх мэт) болон экспортын салбарын үнийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн үйлдвэрлэл, ашигт ажиллагаанд эерэг нөлөөтэй. Цаашдын төгрөгийн ханшийн төвшин нь Монголбанкны валютын зах дахь оролцоо, экспортын болон импортын үнийн төлөв, өрсөлдөх чадвар, эдийн засгийн идэвхжил, санхүүгийн чадавх зэргээс хамаарах болно. Хэдийгээр бизнесийн салбарт олгож буй зээл ихээр нэмэгдэхгүй байгаа боловч сүүлийн 2-3 сарын хугацаанд шинээр олгосон зээл болон зарим төрлийн

хадгаламжийн хүүгийн хэмжээ буурах хандлага ажиглагдаж эхлэв.

Мөнгөний бодлогын ирэх жилийн зорилго юу вэ?

Монголбанкны хувьд 2017 оны мөнгөний бодлогын зорилтыг эдийн засгийг тогтворжуулах гэж тодорхойлж байсан бол 2018 оны мөнгөний бодлого нь эдийн засаг, санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, эдийн засагт эрсдэл хуримтлуулахгүйгээр, инфляцийн дарамт үүсгэхгүйгээр эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэх болно. 2018 он бол эдийн засгийн реформыг тууштай хийх жил болох учиртай. Эдийн засгийн эмзэг байдлыг сууриар нь богино хугацаанд арилгаж чадахгүй тул энэхүү шокийн сөрөг нөлөөг даах чадварыг нэмэгдүүлж, дархлааг нэмэгдүүлэхэд анхаарч, зах зээлийн таатай үед санхүүгийн нөөц чадавхийг бүрдүүлэхэд бодлогоо чиглүүлж байна. Эрдэс бүтээгдэхүүний зах зээл дэх гадаад шокийн дотоод эдийн засагт нөлөөлөх нөлөө том бөгөөд бодлогын нөлөөг давамгайлах хандлага уул уурхайн салбараас хамаарал өндөртэй улс орнуудад ажиглагддаг. Энэхүү хандлага манай улсын хувьд ч ажиглагдаж байгаа нь эдийн засгийн эмзэг байдлын маш том шалтгаан болж байна.

Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, нэмэгдүүлэх нь чухал боловч энэхүү өсөлт дунд, урт хугацаанд тогтвортой хадгалагдах нь бүр илүү чухал юм. Эдийн засгийг идэвхжүүлэхэд хэт яарсан бодлого нь богино хугацаандаа эерэг нөлөө үзүүлж, олон нийтэд таалагдах хэдий ч энэ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад эргэлзээ төрүүлж эргээд өсөлт саарах, унах нөхцөлийг бүрдүүлдэг. Иймд богино хугацааг харсан бодлого биш харин тогтвортой байдлыг зорьсон бодлого бидэнд хэрэгтэй. Ийм ч учраас Монголбанк инфляцийг 2018-2020 онд тогтворжуулах бодлогоо тууштай хэрэгжүүлэхийг зорьж байна. Инфляцийг тогтворжуулахад уягдсан мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь инфляци ба эдийн засгийн өсөлтийн зөв тэнцвэрийг хангах замаар эдийн засгийн өсөлтөөс иргэдийн амьжиргаанд очих нийгмийн хожоог хамгийн өндөр байлгахыг зорино гэсэн хэрэг.

Энэхүү бодлогоо хэрэгжүүлэхдээ эдийн засагт нийлүүлж буй зээлийн төрөл болон өсөлтийг зохистой төвшинд удирдах замаар эдийн засагт эрсдэл хуримтлуулахгүйгээр, инфляцийг хөөрөгдөхгүйгээр тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжих бодлогыг

хэрэгжүүлнэ. Мөнгөний бодлогын энэхүү дунд хугацааны зорилтыг бодлогын хүү болон банкны зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хослуулах замаар хэрэгжүүлнэ. Зээлийн өсөлт эдийн засгийн нэрлэсэн өсөлтөөс хэт ихээр нэмэгдэх, тэр нь иргэд, ААН-ийн санхүүгийн эмзэг байдал, улмаар банкны салбарын эмзэг байдал, эдийн засгийн хэлбэлзэл рүү хөтлөх эрсдэлтэй тохиолдолд түүнээс сэргийлсэн бодлогын арга хэмжээ авна.

Банкны зээлийн эх үүсвэрийг хэрэглээг дэмжсэн зээлээс илүү бизнесийн төсөл, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглүүлэх бодлогыг макро зохистой бодлогын хэрэгслүүдээр дамжуулан хэрэгжүүлнэ. Мөн долларжилтоос сэргийлж, бууруулна. Өрх, ААН, санхүүгийн байгууллагуудын балансын долларжилт эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж, хямралын нөлөөг гүнзгийрүүлдэг болох нь 2008/2009 оны хямрал болон энэ удаагийн үйл явдлаас тод харагдаж байна. Иймд Монголбанкнаас гадаад валютын орлогогүй хэрнээ гадаад валютын зээл авах, банк ийм төрлийн зээл олгохоос сэргийлэх макро зохистой бодлогыг хэрэгжүүлнэ. Зээлийн долларжилт нь банкны пассивын долларжилттой холбоотой учраас түүнийг бууруулахад чиглэсэн бодлогыг давхар хэрэгжүүлэх учиртай. Ингэснээр эдийн засгийн гадаад сөрөг шокийн нөлөөгөөр төгрөгийн ханш сулрах тохиолдолд бодит секторт ирэх сөрөг нөлөө буурах төдийгүй гадаад валютын нөөцийн хүрэлцээг сайжруулахад дэмжлэг болно. Энэхүү бодлогыг амжилттай хэрэгжүүлэхэд эрсдэл даах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай банкны тогтолцоо бүрдүүлэх нь чухал байгаа тул үүнийг хэрэгжүүлэх банкны хяналт шалгалтын тогтолцоог бий болгоно. Мөн түүнчлэн дээрх бодлогын зорилтыг хангаж чадах хараат бус мөнгө, санхүүгийн бодлогын шийдвэр гаргах тогтолцоог Төв банкны тухай хууль, Банкны тухай болон холбогдох бусад хуулийг өөрчлөх замаар бүрдүүлэхийг зорьж байна.

Монгол орны маань Тусгаар тогтнол нь баталгаатай, хүн ард нь амгалан тайван, элбэг хангалуун амьдралтай, эдийн засаг, Санхүү нь өөрийгөө тэтгэн хөгжих чадавхтай улс орон байж, өөдлөн дэвжих болтугай. 2017 оны 12 сарын 1

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

АРГАЛИЙН ТОЛГОЙТОЙ ХОС АЛТАН СҮЛБЭЭР ХОСГҮЙ ҮНЭТ

УРТ: 13-14 см

ӨРГӨН: 2.5-3.3 см

ЖИН: 76.84 гр

Эртний нүүдэлчдийн ур ухаан шингэсэн гайхамшигт хийцтэй өвөрмөц нэгэн дурсгалыг археологич Д.наваан, Ц.Доржсүрэн, В.В.Волков нар 1971 онд илрүүлжээ. Аргалийн толгойг загварчилсан байдлаар ур хийцтэй сайтай үйлдэж, дотогш эргэсэн бахим эвэр, монхор сартгар хамар, хөнхөр том нүдтэй дүрсэлжээ. Энэхүү алтан сүлбээр нь хүрэл зэвсгийн үеийн нүүдэлчдийн оюуны соёл, төмөрлөг боловсруулалтын түвшин, арга ажиллагааг харуулах чухал олдвор болно.



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ МОНГОЛБАНКНЫ САЛБАР

Сүхбаатар аймаг дахь Монголбанкны хэлтэс анх 1942 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн Улсын бага хурлын тогтоолоор “ЖАВХЛАНТ ШАРГА” аймгийн банк нэртэйгээр одоогийн Сүхбаатар аймгийн төвөөс баруун тийш 22 орчим км газарт байсан “Мандлын хийд”-ийн суурин дээр 2 эсгий гэртэйгээр дарга, байцаагч, ерөнхий нягтлан бодогч, мөнгөний нярав, мөнгө хураагч, манаач зэрэг 10 ажилтны бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна. Байгуулагдсан жилдээ 20 гаруй байгууллагад үйлчилж, 401.8 мянган төгрөгийн төлбөр, тооцоо хийж байжээ.

МОНГОЛБАНКНЫ САЛБАР БАЙГУУЛАГДСАН НЬ



Жолооч С.Уранбаяр, Нягтлан бодогч Л.Туяа,
Хянан шалгагч Ө.Туяа, Хянан шалгагч А.Хүрэлтогоо,
Захирал Ц.Мөнхбаяр, Нярав Д.Энхбат

Манай улс 1990 оноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж, банкны 2 шатлал бүхий тогтолцоо үүсэж бий болсон учраас, тус аймгийн банкны контторыг 1991 оны 7 дугаар сарын 08 -ний өдрийн Монголбанкны Ерөнхийлөгчийн 3/61 тоот тушаалаар “Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар” болгон өөрчилжээ. Тус салбар төрийн мөнгөний бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, арилжааны банкуудад хяналт тавих, банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх зэрэг үндсэн үүрэгтэй ажиллаж эхэлсэн байна.

1. ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

Нэг талаас арилжааны банкууд ашгийн төлөө байгууллага учир зохих ёсны үр ашгийг хүртэх, нөгөө талаас банкуудтай хамтран ажиллаж байгаа харилцагч нарын хамтын ажиллагааны үр дүнд бий болох үр ашгийг тооцож ажиллахыг зөвлөж иржээ.

Мөн орон нутгийн удирдлагуудтай “Төрийн бүх төлбөр тооцоог бэлэн бусаар хийж байх”, “Арилжааны банкуудыг сонгож үйлчлүүлэхдээ шударга өрсөлдөөний зарчмыг удирдлага болгон, шалгаруулалтын үндсэн дээр үйлчлүүлэх”, “Хувийн хэвшилд тулгуурласан эдийн


засгийн хөгжлийг дэмжих” зэрэг чиглэлүүдийг удирдлага болгон хамтран ажиллаж байна.

Иргэд, албан байгууллага, жижиг дунд бизнес эрхлэгчид, малчдын болон бусад хурал зөвлөгөөнд оролцож тэдний санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, тухайн үеийн банкны салбарын нөхцөл байдал, мөнгөний бодлого, Монголбанкнаас гаргасан бодлого шийдвэрийг танилцуулж, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж байна.

2. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хяналт шалгалтын үйл ажиллагаанд гүйцэтгэлд суурилсан шалгалтаас татгалзаж эрсдэлд суурилсан “шалган туслах” хяналт шалгалтыг түлхүү хийх болжээ.


Тус аймагт Хаан, Хас, Голомт, Төрийн, Капитал банкны 36 салбар нэгжид 204 ажилтан ажиллаж байгаа бөгөөд 2017 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн хэмжээнд 66.6 тэрбум төгрөгийг хадгаламж, харилцах дансаар татан төвлөрүүлсэн бол, иргэд, аж ахуй нэгж байгууллагад 115.6 тэрбум төгрөгийн зээл олгоод байна.



3. ЭМИССИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Иргэд бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийг өргөн хэрэглэх болсноор гүйлгээнд гарсан мөнгөнөөс илүү хэмжээний мөнгө буцааж тушаагддаг болсон тул 2012 оноос хойш төв банкнаас зузаатгал аваагүй ажиллаж байгаа юм.

Гүйлгээнд гарсан мөнгөний эргэж ирсэн хувь



Тус салбараас санаачилсан ажлуудын нэг нь “Цагаан сар”-ын өмнө жижиг шинэ мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах замаар “БНХАУ-ын юаны эрэлтийг бууруулах”, “гүйлгээнд байгаа муудсан мөнгөн тэмдэгтийг татах”, “мөнгөн тэмдэгтийн бүтцийг зохистой түвшинд байлгах” ажлуудыг 2008 оноос эхлэн амжилттай хэрэгжүүлж ажиллаж байна.

ЗУРАГ ТҮҮХ ...

Улсын банкны аймаг, хотын конторын дарга нар тус аймаг дахь конторын ажилтнуудын хамт /1988-5-18/ Баруун - Урт сум



Аймгийн банкны хэлтсийн гүйлгээний заал 1974 он



Аймгийн банкны контор 1955-1989 он



Харуул Ж.Гэндэнсүрэн



Конторын мөнгө хураагч Г.Дашцэрэн

1937 ОНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ЗООСОН МӨНГӨ

Монгол Улсад 1925-2001 оны хооронд 10 удаа (1925, 1937, 1945, 1959, 1970, 1977, 1980, 1981, 1994, 2001) гүйлгээний зоос гаргажээ. Гүйлгээний зоосыг хуучнаар ЗХУ, Хятад, БНАГУ-д үйлдвэрлэж байсан бол 1970 оноос дотооддоо үйлдвэрлэдэг болжээ. Монголын гүйлгээний зоосыг мөнгө, никель, гууль, хөнгөн цагаан, зэсээр хийсэн байна.

Нүүр тал: Бадам цэцгийн суурийн дээр “мөнгө” гэж монгол бичгээр, нэрлэсэн үнийг зурхайн тоогоор бичсэн.

Ар тал: Соёмбо дүрслэн, зүүн талд нь “Бүгд Найрамдах”, баруун талд нь “Монгол Ард Улс” гэж монгол бичгээр, доод талд нь оныг зурхайн тоогоор бичсэн.



1 мөнгө
Жин: 2 гр, голч: 18 мм, метал: гуулийн хайлш



10 мөнгө
Жин 1.9 гр голч: 18 мм, метал: гуулийн хайлш



2 мөнгө
Жин 3.9 гр голч: 22 мм, метал: гуулийн хайлш



15 мөнгө
Жин 2.7 гр голч: 20 мм, метал: гуулийн хайлш



5 мөнгө
Жин 9.7 гр голч: 28 мм, метал: гуулийн хайлш



20 мөнгө
Жин 3.7 гр голч: 22 мм, метал: гуулийн хайлш



БЕН БЕРНАНКЕ: ХЯМРАЛЫН ХАР МӨР

Холбооны нөөцийн банкны ерөнхийлөгч асан
Бен Бернанкегийн "Хямралын хар мөр" лекцээс

2008 оны сүүлч 2009 оны эхээр санхүүгийн хямрал дээд цэгтээ хүрч, зөвхөн АНУ төдийгүй аж үйлдвэрлэл хөгжсөн бусад улс оронд санхүүгийн зах зээлүүдэд тогтворгүй байдал үүсээд байсан үе. Дэлхийн санхүүгийн систем бүхэлдээ эрсдэлд орж, Холбооны Нөөцийн Банк авралын ганц зээлдүүлэгч байгууллага гэдэг утгаараа бусадтай хамтарч, үндсэн институциуд болон гол гол зах зээлүүдийн тогтвортой байдлыг хангахын тулд богино хугацааны хөрвөх активаар хангаж байсан билээ.

Түүхийг сөхөж харвал Холбооны Нөөцийн Банк өмнө нь хэзээ ч авч байгаагүй, яаралтай цогц арга хэмжээ авсан гэхээсээ илүү Төв банкны хувьд түүхэн үүргээ гүйцэтгэн оршиж байсныг өнөөдөр дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, авралын ганц зээлдүүлэгч гэдэг утгаараа зах зээлд бий болсон үймээн сандралыг намжаахад чиглэгдсэн бодлого хэрэгжүүлсэн. Энэ удаагийн хямрал юугаараа ялгаатай байсан гэвэл институцийн бүтэц өөр байсанд оршино. Банк болоод, хадгаламж эзэмшигчид бус, харин брокер дилерүүд, репо зах зээл, мөнгөний зах зээлийн сангууд, мөн хамгаалагдаагүй богино хугацааны үнэт цаасууд эрсдэлд орсон. Гэхдээ зах зээлд үүссэн үймээнийг намжаахын тулд богино хугацааны хөрвөх чадвартай активаар хангана гэсэн суурь ойлголт нь 1873 онд Бэжетийн бичсэн "Ломбардын гудамж" номонд дурдсан зарчимтай үндсэндээ тохирч байсныг хэлэх нь зүйтэй.

Би Холбооны Нөөцийн банкны үйлдэлд голлон анхаарч байсан тэр үед Холбооны Нөөц дангаараа арга хэмжээ аваагүй юм. Бид АНУ-ын болоод гадаадын Засгийн газруудтай маш нягт хамтран ажилласан. Тухайлбал, Конгресс Хүндрэлтэй активыг дэмжих хөтөлбөр баталсны дараа АНУ-ын Сангийн яам энэ ажилд оролцож эхэлсэн. Сангийн яам банкуудыг хангалттай хөрөнгөтэй байлгахад анхаарч, АНУ-ын Засгийн газар түр хугацаагаар зарим банкны активыг худалдан авч, эзэмшигчийн байр сууринд очсон. Одоо эдгээрийн дийлэнх нь эргээд хуучин

байдалдаа орсон. Холбооны хадгаламжийн даатгалын корпораци маш чухал үүрэг гүйцэтгэсэн. Тодруулбал, гүйлгээний дансны хувьд 250,000 ам.долларын хадгаламжийн даатгалын дээд хязгаарыг өсгөөд, дараа нь энэ хязгаарыг бүр арилгасан. Үүнээс гадна Холбооны хадгаламжийн даатгалын корпораци нь гурван жил хүртэлх хугацаатай компанийн бонд гаргах сонирхолтой банкуудад баталгаа гаргаж өгсөн. Тус корпораци тодорхой шимтгэлээр бонд гаргагчдын баталгааг хангаж, удаан хугацааны санхүүжилт авах боломж бүрдүүлж өгсөн. Ийм учраас Холбооны Нөөцийн Банк болоод АНУ-ын Засгийн газрын агентлагуудын хамтын ажиллагааны үр дүн байсныг одоо харж болохоор байна.

Үүнээс гадна бид гадаадын агентлагуудтай бас нягт ажиллаж байсан. Өмнө нь би валютын своп хэлцлийн талаар ярьсан. Тухайлбал, Холбооны Нөөцийн Банк гадаадын Төв банкуудад америк доллар өгч, оронд нь үндэснийх нь валютуудыг авч байсан. Ингэснээр гадаадын төв банкууд эрсдэлээ өөрсдөө үүрч, америк долларын санхүүжилт шаардлагатай байгууллагууддаа долларын зээл олгож эхэлсэн. Бид хямралыг гэтлэн давахын тулд олон орны Сангийн сайд, зохицуулагчидтай хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсэн болно.

Хямралын хамгийн хүнд үеийн галыг унтраах нь хангалтгүй байсан нь ойлгомжтой. Санхүүгийн болоод банкны системийг бэхжүүлэхэд чиглэгдсэн нэмэлт арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авсан. Жишээлбэл, 2009 оны хавар Холбооны Нөөцийн Банк банкны бусад агентлагуудтай хамтарч АНУ-ын хамгийн том 19 банкинд стресс тестийг удирдан явуулсан нь туйлын эерэг үр дүнтэй байсан гэж би үздэг. Хямралын хамгийн хүнд үе шатыг туулаад удаагүй байхад энэ арга хэмжээг авсан. Америкийн гол гол банкуудын санхүүгийн байдлыг зах зээлд ил тод зарлаж, түүхэнд байгаагүй алхам хийсэн. Стресс тестийн үр дүнд манай банкууд үүнээс ч хүнд хэцүү эдийн засаг, санхүүгийн нөхцөлийг ажрахгүйгээр даван туулах чадвартай нь харагдсан. Ингэснээр хөрөнгө оруулагчдын итгэл эрс нэмэгдэж, банкууд хувийн хөрөнгө босгох боломжтой болж, олон тохиолдолд хямралын үед Засгийн газраас авсан хөрөнгөө хувийн хөрөнгөөр орлуулах боломж бүрдсэн. Хэдхэн долоо хоногийн өмнө Холбооны Нөөцийн Банк ахиад нэг удаа маш өндөр шаардлагатай цогц стресс тестийг хийлээ. Манай

банкууд энэ шалгалтыг тун ч сайн үзүүлэлттэй давсныг энд тэмдэглэх ёстой. Манай банкууд 2009 оноос хойш хангалттай хөрөнгө босгож чадсан нь харагдсан. Олон талаараа манай банкуудын байр суурь хөрөнгийн хувьд хямралын өмнөх үеэс ч илүү өндөр түвшинд очсон байна.

Иймээс банкуудыг зээл олгох горимдоо бүрэн хэмжээгээр шилжихэд чиглэгдсэн иймэрхүү алхмуудыг одоо хүртэл авч байна. Гэхдээ санхүүгийн системийн бүрэн бүтэн байдал хийгээд бүтээмжийг сэргээхийн тулд бид одоо байгаагаасаа арай хэвийн эдийн засгийн нөхцөлд эргэн шилжих ёстой нь харагдаж байна.

Авралын ганц зээлдүүлэгчийн хөтөлбөрүүдийн талаар хэдэн үг хэлэхийг зөвшөөрнө үү. Эдгээр хөтөлбөр нь үр дүнгээ өгсөн гэж би өмнө нь хэлсэн. Эдгээр санхүүгийн төрөл бүрийн институциудын уналтыг удаашруулж, санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг сэргээсэн. Ихэвчлэн 2008 оны намар эхлүүлсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилт үндсэндээ 2010 оны гуравдугаар сар гэхэд дуусгавар болсон. Ингэхдээ хоёр өөр хэлбэрээр өндөрлөсөн.

Нэгдүгээрт, зарим хөтөлбөр жам ёсоороо дуусгавар болсон. Гэхдээ Холбооны Нөөцийн Банк санхүүгийн байгууллагуудад хөрвөх чадвартай актив хэлбэрээр зээл олгохдоо хямралын үеийн бодлогын хүүгээс доогуур хүүтэй зээл олгож байсан ч хэвийн бодлогын хүүгээс арай өндөр байсан. Санхүүгийн системийн савалгаа намдаж, хүүгийн түвшин харьцангуй хэвийн хэмжээндээ эргэж очмогц санхүүгийн байгууллагуудын хувьд Холбооны Нөөцөөс зээл авах сонирхол нь буурч, уг хөтөлбөр жам ёсоороо дуусгавар болсон. Бидэнд уг хөтөлбөрүүдийг зогсоох шаардлага байгаагүй. Тэд өөрсдөө л жам ёсоороо унтарч, алга болсон.

Холбооны Нөөцийн Банк авралын ганц зээлдүүлэгчийн хувьд тодорхой хөтөлбөрүүд хэрэгжүүлэхдээ санхүүгийн маш бага эрсдэл үүрсэн. Ихэнхдээ богино хугацааны зээл олгож байсан гэж би өмнө нь хэлсэн. Түүгээр барахгүй ихэнх зээл барьцаатай байсан. 2010 оны арванхоёрдугаар сард Холбооны Нөөцийн Банкаас хямралын үед олгосон нийт 21 мянган зээлийн талаар дэлгэрэнгүй тайланг Конгресст тавьсан. Энэ 21 мянган зээлээс ганц нь ч дефолт зарлаагүй. Зээл нэг бүр эргэн төлөгдсөн. Энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго нь ашиг олно гэхээсээ илүү санхүүгийн системийг тогтворжуулахад оршиж байсан ч эцсийн эцэст татвар төлөгчид хожсон. Авралын ганц зээлдүүлэгчийн хөтөлбөр гэж үүнийг хэлнэ. Энэ нь санхүүгийн хямралын галыг унтраах, галын хоолой байсан юм.

Асуулт: Та өргөн олныг мөнгөний бодлогын талаар

илүү сайн ойлголттой болгох шаардлагатай гэсэн. Гэхдээ санхүүгийн тогтвортой байдлын ач холбогдлын талаар ямар ч ойлголтгүй, моргейжийн зээлээ төлөх гэж зүдэрч байгаа олон америк хүн банкуудад санхүүгийн тусламжийг зээл хэлбэрээр үзүүлж, дампуурлаас аварсанд хэчнээн дургүйг та мэднэ. Америкчууд энэ бодлогыг хэзээ нэгэн цагт хүлээн зөвшөөрөх болов уу?

Бернанке: Та зөв хэллээ. XIX зуунд бий болсон үүнтэй ижил зарим маргааны цуурай одоо ч бидэнд сонсогдож байна. Энэ асуултад би амархан хариулж чадахгүй. Холбооны нөөцийн банк юу хийсэн, юу хийх гэж байгаагаа олон нийтэд хүргэхийн төлөө их хүчин чармайлт гаргасныг та мэдэж байгаа. Хэвлэлийн хурлаас эхлээд өөр олон арга хэрэгсэл ашигласан. Холбооны Нөөцийн Банк хариуцлагаа гүн гүнзгий ухамсарласан нь харагдаж байгаа. Зөвхөн би өөрөө гэлтгүй Захирагчдын зөвлөл, эсвэл Холбооны Нөөцийн Банкны ерөнхийлөгч нар байнга олон түмэнд хандаж ирсэн. Бид олон янзын арга хэмжээнд оролцож, илтгэл тавьж, бодлогоо ойлгуулахыг хичээдэг. Гэхдээ манай боловсролын байгууллагууд, хэвлэл мэдээлэл гээд бүгд энэ талаарх хүмүүсийн ойлголтыг дээшлүүлэхийн төлөө чадах бүхнээ хийнэ гэж найдаж байна. Бид өөрсдөө ч чадах бүхнээ хийнэ. Энэ тун амаргүй асуудал.

Асуулт: Ипотекийн зээлээ цаг тухайд нь төлдөг орон сууц эзэмшигчдийг одоогийн хүүгийн түвшнээр дахин санхүүжилт авах боломжийг бүрдүүлж, орон сууцных нь үнэ ханш унахаас хамгаалах хөтөлбөр яригдаж байгаа тухай уншсан. Энэ талаар сонссон уу? Холбооны Нөөцийн Банк үүнд ямар оролцоотой байх вэ?

Бернанке: Иймэрхүү хөтөлбөр хэд хэд бий. Үүний нэг нь Хүндрэлтэй активыг дэмжих хөтөлбөр. Энэ хөтөлбөрийг Засгийн газрын дэмжлэгтэй Fannie болон Freddie, мөн тэдний зохицуулагч Холбооны Орон Сууцны Санхүүжилтийн Агентлаг хэрэгжүүлдэг. Хэрэв таны ипотекийн зээлийн төлбөр орон сууцны бодит үнэ ханшаас илүү гарсан байвал, хэрэв та ипотекийн зээлээ Fannie, Freddie хоёроос авсан бол энэ хөтөлбөрийн дагуу бага хүүгээр санхүүжилт авч, төлбөрийн хэмжээгээ бууруулах боломжтой. Гэхдээ банкууд энэ хөтөлбөрт хамрагдаагүй учраас таны ипотекийн зээлийг банк эзэмшиж байсан тохиолдолд та дээрх үйлчилгээг авч чадахгүй байж магадгүй.

Холбооны Нөөцийн Банк иймэрхүү хөтөлбөрүүдэд оролцдоггүй. Бид бодлогын хүүг бага түвшинд барьснаар орон сууц эзэмшигчдэд тус болно гэсэн хүлээлттэй байдаг. Иргэдийн ипотекийн төлбөрийн хэмжээг бууруулахад чиглэгдсэн иймэрхүү хөтөлбөрүүд хүмүүсийн санхүүгийн

дарамтыг багасгаад зогсохгүй төлбөрийг чадваргүй болох эрсдэлээс зохих хэмжээгээр сэргийлж чаддаг нь ойлгомжтой.

Асуулт: АНУ-ыг дайрч өнгөрсөн сүүлийн хоёр хямралыг харвал дефляци бий болох эрсдэл байсан учраас Холбооны нөөцийн банк өнгөрсөн 10 жилийн эхэнд, мөн одоо мөнгөний маш зөөлөн бодлого баримтлах шаардлага гарсан. Инфляцийн хоёр хувийн зорилтот түвшин дефляциас хамгаалахад хангалттай юу? Цаашид инфляцийн зорилтот түвшнээ өсгөх бодол байгаа юу?

Бернанке: Энэ үнэхээр мундаг асуулт байна. Энэ талаар их судалгаа хийгдэж байгаа. Олон улсын туршлагыг харвал ерөнхийдөө хоёр хувийг хамгийн томхиромжтой гэж үзсэн. Ихэнх төв банкны инфляцийн зорилтот түвшнийг харвал хоёр, эсвэл 1-3 хувийн хооронд хэлбэлздэг. Гэхдээ алтан дунджийг олох нь чухал. Нэг талаасаа таны хэлснээр дефляцийн эрсдэлийг бууруулж, эсвэл бүр мөсөн зайлсхийхийн тулд зорилтот түвшнээ тэг хувиас дээгүүр барих ёстой. Нөгөөтэйгүүр инфляци хэт өндөр байсан тохиолдолд энэ нь зах зээлд муугаар нөлөөлөх эрсдэлтэй. Эдийн засгийн бүтээмжийг бууруулах аюултай учраас хамгийн тохиромжтой дунджийг олох ёстой. Өөрөөр хэлбэл, дефляциас хамгаалах түвшинд барихын зэрэгцээ хэт өсгөж, зах зээлийг сааруулахгүй байх ёстой гэсэн үг. Олон улсын туршлагыг харвал хоёр хувийг илүүд үздэг бөгөөд холбооны Нөөцийн банк ч энэ түвшинг албан бусаар нэлээд удаан баримталж ирсэн. Бид энэ байр сууриа ойрын хугацаанд л лав өөрчлөхгүй. Гэхдээ шинжээчид хамгийн тохиромжтой түвшнийг тодорхойлохын тулд ажлаа үргэлжлүүлэх ёстой.

Асуулт: Та энэ санхүүгийн хямралаас нэг том сургаж авсан гэсэн. Мөнгөний бодлого нь мундаг том хэрэгсэл боловч бүхнийг дангаараа шийдэх боломжгүй гэсэн, ялангуяа бүтцийн шинж чанартай асуудлыг. Иймээс орон сууц, зээлийн болоод санхүүгийн зах зээлд байгаа бүтцийн шинж чанартай хүндрэлийг үр дүнтэй шийдэхээр ямар хэрэгсэл ашиглах вэ?

Бернанке: Энэ ямар хүндрэл байгаагаас шалтгаална. Орон сууцны зах зээлийн талаар Холбооны Нөөцийн Банк тайлан гаргаж, олон хүчин зүйлийг судалж үзсэн. Ингэхдээ зөвхөн төлбөрийн чадваргүй болсны улмаас байшингаа хураалгаж байгаа асуудлыг хөндөөд зогсохгүй эзэнгүй орон сууц, ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх зэрэг асуудлыг авч хэлэлцсэн. Энэ асуудал үнэн хэрэгтээ АНУ-ын Конгресс болоод өөр агентлагуудын эрх мэдэлд байдаг учраас бид тодорхой санал гаргаагүй. Гэхдээ

бид нэлээн өргөн хүрээтэй боломжит арга замуудыг авч үзсэн. Орон сууцны зах зээлийн хүндрэлийг шийдэхэд туйлын амаргүй ч сайжруулахын тулд олон янзын арга хэмжээ авах боломжтой. Fannie, Freddie хоёрт тохиолдсон хүндрэлээс үүдээд АНУ-ын орон сууцны санхүүгийн зах зээл урт хугацааны ирээдүйд ямар байх ёстой гэдэг талаар гаргасан томоохон шийдвэрүүд бий.


Жишээлбэл, Европт маш хүнд хэцүү нөхцөл үүссэн тул бид Европын түншүүдтэйгээ маш нягт ажиллаж байгаа. Тэд хэд хэдэн тодорхой алхам хийсэн. Яг одоо тэд “хамгаалалтын хана” босгож байна. Хэрэв аль нэг улс дефолт зарлаж, өр төлбөрөө барагдуулж чадахгүйд хүрвэл сөрөг нөлөөг нь бусад оронд дамжуулахгүйн тулд хэдий хэмжээний мөнгө зарцуулах талаар ярьж байна. Тийм учраас эмгэг бүрт тохирсон эмчилгээ хэрэгтэй.

Асуулт: Эдийн засгийн сэргэлт маш удаашралтай байгаа ч тодорхой ахиц гарч байгаа гэж та ярьсан. Хувийн сектор хөл дээрээ тогтож, эдийн засгийн сэргэлтэд хүчтэй дэмжлэг үзүүлж эхэлснээр Холбооны Нөөцийн Банк мөнгөний бодлогоо чангатаж магадгүй нөхцөл бүрдэж буйг та ямар үзүүлэлтүүдээр дүгнэж болох вэ?

Бернанке: Маш гоё асуулт байна. Саяхан тодорхой үзүүлэлтүүд сайжирч эхэлсэн. Бид үүнийг туйлын анхааралтай ажиглаж байгаа. Хөдөлмөрийн зах зээл, ажлын байр, ажилгүйдлийн түвшин, ажилгүйдлийн даатгал хүсэгчдийн тоо, ажлын цаг зэрэг үзүүлэлтийг харвал хөдөлмөрийн зах зээл ерөнхийдөө сайжирч байгаа гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Ажилгүйдлийг бууруулах нь манай үндсэн хоёр зорилтын нэг яах аргагүй мөн учраас бид хөдөлмөрийн зах зээлийг тогтвортой гольдрилд оруулахыг маш чухал гэж үздэг нь ойлгомжтой.

Хэрэв эрэлт бүхэлдээ нэмэгдэж, нийт өсөлт сайжирвал хөдөлмөрийн зах зээлд аяндаа ахиц гарна гэж би хэлсэн. Тийм учраас бид хэрэглэгчийн зарцуулалт, хэрэглэгчийн итгэл, хөрөнгийн төлөвлөгөө, хөрөнгийн зарцуулалт, компаниудын итгэлийн индекс, үйлдвэрлэл, мөн эрэлт ямархуу байгаа зэрэг олон үзүүлэлтэд тасралтгүй анхаарах болно. Үнийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийн түвшнийг доогуур, тогтвортой байлгахын тулд мэдээж инфляцийг нүд салгалгүй ажиглана. Бид ийм юманд анхаарах болно. Энэ бүхнийг шийдэх хялбар арга гэж байхгүй. Гэхдээ эдийн засаг бэхжиж, тогтвортой замдаа орж эхэлсний дараа Холбооны Нөөцийн Банкны зүгээс үзүүлж байгаа энэ их дэмжлэгийг аажим аажмаар багасгана.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 20/XII ӨДРИЙН БАЙДЛААР)



ECONOMICS

2008 ОНЫ НОБЕЛИЙН ШАГНАЛ ПОЛ КРУГМАН БА ГАДААД ХУДАЛДААНЫ ОНОЛД ХИЙСЭН ТҮҮНИЙ НЭЭЛТ



“Монголбанкны Мэдээлэл” товхимолд эдийн засгийн салбарт хийгдсэн томоохон нээлтүүдийг тайлбарлан таниулах зорилгоор Нобелийн шагналтнуудын буланг нээсэн билээ. Нобелийн нэрэмжит шагналыг анх 1901 онд 5 чиглэлд олгож эхэлсэн бөгөөд түүнээс хойш 67 жилийн дараа 1968 оноос Шведийн төв банкны санаачилга болон хандиваар эдийн засгийн шинжлэх ухаанд чухал нээлт хийсэн эрдэмтэн судлаач нарыг жил болгон шалгаруулж, шагнал гардуулдаг болжээ. Энэ дугаарт бид 2008 онд эдийн засгийн салбар дахь Нобелийн шагналыг хүртсэн эрдэмтэд болох Пол Кругманыг танилцуулж, түүний судалгааны ажлыг энгийн үг хэллэгтэйгээр тайлбарлан хүргэхийг зорилоо.

Гадаад худалдааны уламжлалт онол

Гадаад худалдаа, түүнийг судалдаг эдийн засгийн онол болон сэтгэлгээ нь эрт дээр үеэс үүсэлтэй. Эртний Грек болон Хятадын их сэтгэгч нар энэ тал дээр философийн суурийг нь тавьж өгсөн. Гэхдээ 1800-аад оны эхээр Английн эдийн засагч Дэвид Рикардо харьцангуй давуу тал нэртэй онолыг дэвшүүлж, баталж чадсанаар өнөөгийн худалдааны онол буюу эдийн засгийн нэг чухал судлагдахууны гол үндэс болсон юм. Рикардогийн онолыг хожим нь Эли Хекшер, Бертиль Олин гэдэг Шведийн эдийн засагчид 1920-оод оны үед дэлгэрүүлж, Хекшер-Олины загварыг боловсруулсан.

Рикардогийн онол ёсоор улс орнуудын газар зүй болон нийгмийн өөр байдал нь тодорхой нэг бүтээгдэхүүн, үйлчилгээг бүтээх үйлдвэрлэл буюу технологийн давуу

талыг бий болгож, энэ нь цаашлаад чөлөөт худалдааны явцад нэг улс нөгөө улсаасаа харьцангуй давуу байх боломжийг олгодог. Энд алдагдсан боломжийн өртөг чухал бөгөөд алдарт жишээ бол Англи Улс вино үйлдвэрлэж байснаас хувцас үйлдвэрлэсэн нь өртөг багатай бөгөөд харин Португал Улс эсрэгээрээ байх аж. Хекшер-Олины загварт үйлдвэрлэлийн хүчин зүйлс буюу бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэхэд ашиглах газар, капитал, хөдөлмөр тус бүрийг чухалчилж харьцангуй давуу талыг бүрдүүлэхэд нөлөөлнө гэжээ. Иймээс зарим улс газар тариалангийн бүтээгдэхүүн худалдаалах харьцангуй давуу талтай байхад, бусдад нь үйлдвэрийн бүтээгдэхүүнд илүү байх жишээтэй.

Харамсалтай нь гадаад худалдааны уламжлалт гэгдэх эдгээр онолууд нь цаг хугацааны эрхэнд хүчээ алдаж, илүү боловсронгуй онол бий болох орон зайг үүсгэсэн. Тухайлбал Нобелийн эх орон Швед Улсад өнөөдөр Волво автомашиныг үйлдвэрлэж зардаг ч, гаднаас мөн их хэмжээгээр BMW маркийн машиныг худалдаж авдаг. 30 гаруй жилийн өмнө Пол Кругман уламжлалт худалдааны онолоор тайлбарлаж чадаагүй үзэгдлийг судалж цоо шинэ худалдааны онолыг бий болгосон.

Пол Кругман

Тус эрхэм нь АНУ-ын Принстон болон Нью Йорк хотын сургуулиудад профессор хийдэг бөгөөд мөн Нью Йорк Таймс сонины нийтлэлч юм. Тэрбээр нэгэн ярилцлагадаа “би олон зүйлийг хийж чадахгүй ч, миний хамгийн сайн хийж чаддаг зүйл бол бичих. Би маш хурдан бичдэг.



Тийм ч учраас олон зүйлийг амжуулж чаддаг байх” гэжээ. Пол Кругман бол АНУ-ын хамгийн нөлөө бүхий улс төр, эдийн засгийн нийтлэлчдийн нэг юм.

Пол Кругман 20 гаруй ном бичихэд оролцож, 200 орчим удаа мэргэжлийн сэтгүүлд нийтлэлээ хэвлүүлж байсан нэгэн. Тэрбээр 1953 онд Нью Йорк хотод оршин суудаг еврей гэр бүлд төрсөн бөгөөд түүний аав одоогийн Беларусаас гаралтай. Түүний эдийн засагт дурлах болсон нь Исаак Азимовын шинжлэх ухааны зөгнөлт романуудаас үүдэлтэй юм. Ялангуяа “суурь” нэртэй цуврал романуудад гардаг психо-түүх буюу математик тооцоолол, нийгэм судлал, түүх судлалыг нэгтгэж судалдаг зөгнөлт шинжлэх ухааныг ашиглаж хүн төрөлхтнийг аварч байгаа нь түүнд ихээр нөлөөлснийг дурдсан аж. Кругман Иелийн их сургуулийг онц сайн дүнтэй дүүргэж, Массачусетийн Технологийн Институтэд докторын зэргээ “уян хатан тогтох валютын ханш” сэдвээр хамгаалжээ. Түүний диссертацийн удирдагч нь Руди Дорнбуш байсан ба олон улсын эдийн засаг, мөнгөний бодлого, гадаад худалдааг судлахад бүх насаа зориулсан нэгэн. Кругман хэлэхдээ “Дорнбуш эдийн засгийн багш нараас хамгийн шилдэг нь ба түүний өрсөлдөөнт монополий худалдааны загвар нь нобелийн шагнал хүртэх судалгааны ажлын минь сэдлийг өгсөн” гэжээ. Economies of scale буюу хэмжээнээс хамаардаг бизнес гэдэг санаа нь 1979 онд түний нийтлүүлж байсан 10 хуудас нийтлэлд тусгалаа олсноор Нобелийн шагнал хүртэх гадаад худалдааны онолын суурь болжээ. Уг нийтлэлд масс үйлдвэрлэл бүтээгдэхүүний үнийг бууруулдаг гэдэг магадлалыг тайлбарлаж, туршсан бөгөөд хэдийгээр өнөөдөр энгийн ойлголт болсон боловч тухайн үедээ хувьсгал хийсэн юм.

Хэрэглэгчид өргөн сонголтыг эрхэмлэдэг


Хүмүүсийн хэрэгцээ эхэндээ энгийн нэг бүтээгдэхүүн авах төдийд хангагддаг боловч он цагийн эрхэнд, үйлдвэрлэгч, брэндүүдийн төрөл ихэссэнээр сонголт хийх хүсэл эрмэлзэл мөн нэмэгддэг байна. 1977 онд Аваниш Диксит, Жосеф Штиглиц нар бүтээгдэхүүний төрөл олон янз байх нь хэрэглэгчдийн сонголтод эергээр нөлөөлдгийг туршсан загвар боловсруулсан байна. Тус загварт хэмжээнээс хамаардаг бизнест олон өрсөлдөгчид бий болсон ч тухайн үйлдвэрлэгч нь бүтээгдэхүүний мөн чанар болон үйлдвэрлэх хэмжээнд анхаарснаар ашигтай ажиллаж болохыг харуулсан юм. Кругман аль нэг улсын салбарын хэмжээнд бус олон улсын худалдааны тавцанд энэ загварыг туршсанаар улс орнууд нэг нэр төрлийн бүтээгдэхүүнийг өөр загвар, бүтэц, хийц, тоо ширхгээр үйлдвэрлэсэн ч өндөр ашиг олж болохыг тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл хэмжээнээс хамаардаг гадаад худалдаанд өрсөлдөгч нар нэмэгдсэнээр бүх талууд ашигтай байж болно.

Эдийн засгийн газар зүй

Эдийн засгийн газар зүй гэдэг ойлголт нь бүтээгдэхүүн, үйлчилгээг хаана бүтээж байна гэдгийг судлаад зогсохгүй, тухайн улс орны ажиллах хүч, капиталын хүртээмжийг судалдаг судлагдахуун юм. Кругманы гадаад худалдааны онолын онцлог нь хэмжээнээс хамаардаг бизнес гэдэг ойлголтыг тээврийн зардал буурахтай холбож нэгдмэл загвар боловсруулсанд оршиж байгаа. Хэрэв хоёр улс бүх зүйлээр ижил боловч, нэг нь нөгөөгөөс хүн амаар илүү байхад тэр улсын бүтээмж, цаашлаад бодит цалингийн хэмжээ өсдөг. Хэрэв цалингийн хэмжээ өсөж, тээврийн зардал буурвал шилжих хөдөлгөөн бүр их нэмэгддэг гэсэн жишээг тэрбээр 1979 оны нийтлэлдээ дурджээ. Гэхдээ хожим нь Кругман онолоо дахин шалгаж, core-periphery model буюу төв-зах хязгаарын загвар дээр туршсанаар зарим хүмүүс техник технологийн дэвшилтэй газарт шилжиж байхад өөр нэг хэсэг нь сонголтоороо хотоос дайжиж хөдөө орон нутагруу нүүдэг болохыг тогтоожээ. Энэ нь тэнцвэрт байдлыг хангаж байдаг аж.

Эх сурвалж: https://www.nobelprize.org/nobel_prizes/economic-sciences/laureates/2008/press.html

БАНКНЫ САЛБАРЫН БОЛЗОШГҮЙ ХҮНДРЭЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУД



МОНГОЛБАНКНААС УЛИРАЛ БҮР ЭРХЛЭН ГАРГАДАГ
"МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" СЭТГҮҮЛИЙН ГУРАВ ДАХЬ
ДУГААРААС ОНЦЛОН ХУРААНГУЙЛАВ.

Доожавын Ган-Очир¹

Монгол Улсын Засгийн газар ОУВС-гийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийг 2017 оны тавдугаар сараас эхлэн хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх бүтцийн шинэчлэлийн нэг нь банкны салбарт үйл ажиллагаа явуулж буй банк тус бүрийн активын чанарын үнэлгээ хийж, түүний үр дүнд суурилан банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийх, хүндрэлийг шийдвэрлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэхээр болсон. Манай орны хувьд өмнө нь 1996-1999 оны банкны хямралын үед банкны бүтцийн өөрчлөлт хийгдэж байсан бөгөөд энэ удаагийнх хорь орчим жилийн дараа хийгдэх гэж байна. Энэ хугацаанд банкны хүндрэлийг шийдвэрлэх арга замууд нэвтэрч, улс орнуудын туршлага, алдаа, онооны талаар нэлээд судалгаа хийгдсэн. Энэхүү нийтлэлд банкны салбарын хүндрэлийн шалтгаан, эдийн засагт үүсгэх зардал, хүндрэлийг шийдвэрлэх арга замыг сүүлийн жилүүдэд хийгдсэн судалгаанд тулгуурлан авч үзлээ.

Банкны хямрал нь бүх банк шокын ижил цохилтод орох, нэг банк, эсвэл банкны нэгдэл дампуурснаар салбарын бусад банкинд сөргөөр нөлөөлснөөр олон тооны банк цаг хугацааны ойролцоо агшинд мөнгөн хөрөнгийн дутагдалд орж, үйл ажиллагаагаа цаашид хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болох үед тохиолддог. Хэдийгээр шалтгаан нөхцөл нь урт хугацаанд хуримтлагддаг хэдий ч хямрал нь санхүүгийн зах зээлийн төлөвийн талаарх хувийн салбарын төсөөлөлд гарч буй гэнэтийн өөрчлөлт, эсвэл макро эдийн засгийн тогтворгүй байдлаас хамаарч үүсдэг.

Brooke ба бусад (2015) нар банкны хямралын эдийн засгийн зардлын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д үзүүлэх нөлөөллийг тооцож байжээ. Ихэнх тохиолдолд банкны хямралын зардал маш өндөр байдаг. Мөн

¹ Эдийн засгийн ухааны доктор (Ph.D.), Монголбанкны Судалгаа, статистикийн газрын Захирал.

хөгжингүй дундаж орны хувьд банкны хямралын хамгийн их алдагдал нь дөрвөн жилийн дараа ажиглагддаг болохыг харуулжээ. Банкны хямралын шууд болон шууд бус сувгаар дамжин төсвийн зардалд үзүүлэх нөлөөллийг Зураг 2-т харуулав.

Зураг 2. Банкны хямралын төсвийн зардалд нөлөөлөх сувгууд



Эх сурвалж: Amaglobeli ба бусад (2015).

1. Банкны хямралыг шийдвэрлэх арга зам

Хямралын удирдлага нь гурван хэсгээс бүрддэг. Эхний зорилт нь банкны хүндрэл, хямралын тархалтыг зогсоох юм. Энэ зорилт хангагдсан тохиолдолд эрх баригчид дараагийн хоёр алхам болох банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийх, татан буугдсан, бүтцийн өөрчлөлт хийгдсэн банкны активыг удирдах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Эдгээр алхмыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дараах дэд хэсэгт үзье.

1.1. Банкны хямралын тархалтыг зогсоох.

Төрийн байгууллагын нэн тэргүүний авч хэрэгжүүлэх арга хэмжээ нь банкны хямралыг зогсоох явдал юм. Үүнд (i) эх үүсвэрийн яаралтай тусламж олгох, (ii) төрөөс банкин дахь депозитод баталгаа гаргах, (iii) захиргааны арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг алхмууд багтана. Эдгээр арга хэмжээ нь банкны хямралын тархалтыг зогсооход нэн тэргүүний хэрэгжүүлэх

алхмууд хэдий ч бүгд тодорхой эрсдэлийг дагуулж байдаг. Иймд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрийн сөрөг нөлөөг анхаарч үзэх шаардлагатай.

1.2. Банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийх.

Банкны салбарын бүтцийн өөрчлөлт нь хүндрэлийг шийдвэрлэх асуудлын цөм нь юм.

(i) Банкны салбарын иж бүрэн оношлогоо: Активын чанарын үнэлгээ, стресс тест. Активын чанарын үнэлгээ нь банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, санхүүгийн нөхцөл байдлыг үнэлэх, тодорхой бус байдлыг бууруулах, итгэлцлийг нэмэгдүүлэх оношлогооны гол хэрэгсэл юм. Активын чанарын үнэлгээг хийхийн өмнө бодлого боловсруулагчид чанарын үнэлгээгээр илэрч болзошгүй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох стратегийг боловсруулах шаардлагатай.

(ii) Банкны хүндрэлийг шийдвэрлэх хувилбар. Банк тус бүрийн хувьд активын чанарын үнэлгээ хийгдэж дууссанаар үнэлгээнд суурилан бодлого боловсруулагчид банкныг ангилж (бүх шалгуур нөхцөлийг ханган ажиллаж буй; үйл ажиллагаа нь хэвийн үргэлжлэх боломжтой, гэхдээ өөрийн хөрөнгийн дутагдалд орсон; үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэх боломжгүй гэсэн гурван хэсэгт хуваана), банкны бүтцийн өөрчлөлтийн стратегийг боловсруулдаг.

Банкны бүтцийн өөрчлөлтийн стратегийг ерөнхийдөө хувийн секторт суурилсан, төрийн оролцоотой гэж хоёр ангилдаг:

- **Хувийн секторт суурилсан шийдэл.** Банкны хувь эзэмшигчид банкаа дахин хөрөнгөжүүлэх, бүтцэд өөрчлөлт оруулах эхний боломжоор хангах ёстой (шинэ хувийн хөрөнгө оруулагч оруулж ирэх г.м.).
- **Төрийн оролцоотой шийдэл.** Хувийн секторт суурилсан шийдэл амжилтгүй болох, банк төлбөрийн чадваргүй болох нь зайлшгүй тохиолдолд тухайн банкныг дампууралд хүргэх албагүй юм.

Төрөөс оролцох, худалдах. Хэрэв одоогийн болон шинэ хувь эзэмшигчид нь банкинд бүтцийн өөрчлөлт хийж чадахгүй бол хянан шалгагчид төлбөрийн чадваргүй, эсвэл өөрийн хөрөнгийн дутагдалд орсон банкны хяналтыг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хүлээн авч, банкны эздэд алдагдлыг үүрүүлж, банкныг хэсэгчлэн болон бүтнээр худалдана.

Төрөөс дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөө. Хувийн секторт суурилсан шийдлүүд нь хангалтгүй болсон үед төрийн оролцоо нь банкны дампуурлаас эдийн засагт бий болох зардлыг бууруулна.

Банкийг татан буулгах, хөрөнгийг депозит эзэмшигчдэд тарааж, активыг эргэн төлүүлэх. Банк үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болох, эсвэл сонирхсон хөрөнгө оруулагчийг олж чадаагүй тохиолдолд тус банкны активыг цуглуулж, өр төлбөрийг барагдуулна.

Банкийг төрд шилжүүлэн авах. Хэрэв шинэ, эсвэл өмнө нь байсан хувь эзэмшигчидтэй хамтран өөрийн хөрөнгийг сэргээх оролдлого нь бүтэлгүй болж, гэхдээ тухайн банкныг татан буулгах нь санхүүгийн салбарын тогтворгүй байдлыг үүсгэхээр тохиолдолд тухайн банкныг төр шилжүүлэн авахаас өөр сонголт үлдэхгүй.

Шалгуур үзүүлэлтэд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх. Шалгуур үзүүлэлтийн журмыг хэрэгжүүлэхийг хянан шалгагч байгууллагаас шаардахгүй тохиолдолд хөнгөлөлт, чөлөөлөлт бий болдог.

1.3. Активын удирдлага, корпорацын өрийн бүтцийн шинэчлэл, Актив удирдлагын компани (АУК).

Банкны чанаргүй актив нь хямралын үр дагавар учраас чанаргүй активыг хэрхэн зохистой удирдах, тараан байрлуулах нь банкны хямралын үр дагаврыг шийдвэрлэх хамгийн чухал асуудал байдаг. Иймд активын удирдлага болон корпорацын өрийн бүтцийн шинэчлэл нь хямралын удирдлагын сүүлийн багц арга хэмжээ (банкны салбарын оношлогоо, түүнд суурилсан бүтцийн өөрчлөлтийн дараах) юм. Активын удирдлага гэдэгт чанаргүй активыг эхэлж тодорхойлох, түүний шинж байдалд тулгуурлан дараах дөрвөн хэсэг (худалдах, сэргээх, бүтцийг шинэчлэх болон эдгээр хөрөнгийг тэнцлээс хасах)-т хамаарах үйл ажиллагаа эрхлэхийг ойлгодог:

Чанаргүй хөрөнгийг худалдах. Тухайн төрлийн хөрөнгийн зах зээл байх ёстой бөгөөд байхгүй бол бий болгох ёстой. Чанаргүй хөрөнгийг худалдах нь эрсдэлийг тарааж, нөөцийн дахин хуваарилалтыг бий болгоно.

Чанаргүй хөрөнгийг сэргээх. Хөрөнгийг эзэмшигч нь өөрийн хөрөнгийн өртгийг түүний барьцаанд байгаа эд хөрөнгийг борлуулах замаар олж авах үйл явц юм. Энэ нь эрх зүйн орчин, хэрэгжүүлэх арга замаас ихээхэн хамаардаг.

Чанаргүй хөрөнгөнд бүтцийн өөрчлөлт хийх. Хөрөнгө эзэмшигч нь хөрөнгийн үүрэг хүлээгч (зээлдэгч)-тэй тохиролцоо хийх бөгөөд зээлдэгч хүүний төлбөр, цаашлаад үндсэн төлбөрөө төлөх чадварыг сайжруулахыг зорино.

Чанаргүй хөрөнгийг тэнцлээс хасах. Хөрөнгө эзэмшигч тэнцэл дээрх өртгөөр алдагдал хүлээж, тэнцлээс хасалт хийнэ.

1.4. Банкны дахин хөрөнгөжүүлэлт, бүтцийн өөрчлөлтийг Засгийн газрын бондоор санхүүжүүлэх.


Банкны бүтцийн өөрчлөлтийн үед Засгийн газрын бонд гаргах ерөнхий хоёр зорилго байдаг. Засгийн газар банкны хөрөнгийг дахин хөрөнгөжүүлэх, банкны чанаргүй активыг худалдаж авах аргыг санхүүжүүлэх явдал юм. Засгийн газрын бондыг дахин хөрөнгөжүүлж буй банкинд шууд байршуулах нь: i) урт хугацаатай Засгийн газрын бондын дотоодын зах зээл хөгжөөгүй байсан ч хэрэгжих боломжтой; (ii) хямралын үед Засгийн газар дотоод зах дээр бонд гаргахыг хүсэхгүй, эсвэл боломжгүй байсан ч банкны дахин хөрөнгөжүүлэлтийг хийх боломжтой зэрэг давуу талтай. Харин сөрөг тал нь бондоор хөрөнгө, эсвэл өөрийн хөрөнгөнд төлбөр хүлээн авч буй банк нь чөлөөт эх үүсвэрийн хязгаарлалтад орох эрсдэлтэй. Хэдийгээр тухайн банк үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжтой болсон ч хадгаламж татагдах үед түүнийг хангах хангалттай хэмжээний чөлөөт эх үүсвэргүй болсон тохиолдолд банк хүндрэлд орох эрсдэл өндөр хэвээр байна. Хэрэв бусад банк тодорхой хэмжээний илүүдэл нөөцгүй, бусад дотоод, гадаад хөрөнгө оруулагчид Засгийн газрын бондыг сонирхохгүй тохиолдолд дахин хөрөнгөжүүлсэн банк бондоо зарж, эх үүсвэр бүрдүүлж чадахгүйд хүрнэ.

2. Банкны хүндрэлийг шийдвэрлэхэд анхаарах асуудлууд

- Улстөрийн дэмжлэг чухал. Хямралын менежмент болон шийдвэрлэх арга зам нь тухайн нийгэм дэх баялгийн дахин хуваарилалтыг хийх явдал юм.
- Банкны хүндрэлийн зөв оношлогоо, шийдэл. Эрх бүхий байгууллага дампуурч буй банкны асуудлыг хяналтад шуурхай авснаар хүндрэлийг шийдвэрлэх зардал буурах боломж бүрдэнэ.
- Банк дампуурахыг зөвшөөрөх ёстой. Банкны дампуурал нь банкны салбарын тогтвортой

байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлж болно.

- Банкны хүндрэлийг шийдэхдээ ижил тэгш, шударга зарчмыг баримтлах. Бүтцийн өөрчлөлтийн бодлого нь бүх банкинд ижил үйлчлэхээр хэрэгжих ёстой.
- Банкны бүтцийн өөрчлөлт нь цогц байдлаар боловсруулагдаж, цаг хугацааны туршид өргөжин боловсронгуй болох. Хүндрэлийг шийдвэрлэхээр сонгосон хувилбар нь банкны зөвхөн одоогийн асуудлыг шийдэх бус, хууль эрх зүйн орчин, институцийн тогтолцоонд байгаа дунд хугацааны асуудлыг ч мөн давхар шийдвэрлэх шаардлагатай.
- Эдийн засгийн эрх бүхий байгууллагууд нягт хамтран ажиллах. Хэдийгээр банкны салбарын хүндрэлийг шийдвэрлэхэд эрх зүй болон үйл ажиллагааны хуваарилалт зайлшгүй боловч, хамтран ажиллах, хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээ харилцан мэдээлэх механизмыг бүрдүүлэх нь чухал юм.
- Депозит эзэмшигч, бусад зээлдүүлэгч нарын эрх ашиг хамгаалагдах. Хямралтай нүүр тулсан үед зардал нь төсвөөс гарах боломжтой бол банкны эх үүсвэрт төрөөс батлан даалт гаргаснаар зээлдүүлэгч нарын айдсыг бууруулж, сул банкныг татан буулгахад туслах юм.
- Банкны дампуурлыг хариуцах этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх. Банкны үйл ажиллагааг алдагдуулж, буруу ажилласан захирал, удирдлагад хариуцлага хүлээлгэх нь санхүүгийн зах зээлд сахилга бат тогтоодог.
- Активыг эргэн төлүүлэх.. Асуудалтай активын төлөв байдалтай аль болох эрт танилцаж, түүнийг төлүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах нь зээлийн сахилга батыг хангахад чухал юм.
- Төрийн батлан даалтаас гарах. Бүтцийн өөрчлөлтийн стратегийн нэг хэсэг болгон аливаа төрлийн батлан даалт төрөөс гаргасан бол санхүүгийн тогтвортой байдалд аюул учруулахгүйгээр аль болох богино хугацаанд батлан даалтаас гарах ёстой.



БАГА НАСНЫ ХҮҮХДЭД САНХҮҮГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ ОЛГОХ АСУУДАЛД

ХҮИС-ийн багш Д.Оюунцэцэг (Ph.D)

Улс орон бүр иргэддээ санхүүгийн боловсрол олгож, тэдний бизнесийн болон санхүүгийн мэдлэгийг дээшлүүлж байх нь урт хугацаанд тогтвортой хөгжих үндэс суурийн нэг болдгийг дэлхийн өндөр хөгжилтэй олон орны туршлага нотлон харуулсан. Иргэдийн санхүүгийн мэдлэг дээшлэхийн хэрээр тэдний хуримтлал, хадгаламжийн хэмжээ нэмэгдэх, өр зээлийн хэмжээ буурах, санхүүгийн боломж нь сайжрах зэрэг ач холбогдолтой юм. Улмаар үнэт цаасны хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж хөрөнгийн зах зээл хөгжих, даатгалын ач холбогдлыг ойлгосноор даатгуулагчдын тоо өсөж даатгалын зах зээл өргөжих, санхүүгийн луйвар, залиланд өртөгсдийн тоо буурах, ядуурал багасах зэрэг урт хугацааны эерэг үр дагавар гарах юм. Иймээс санхүүгийн боловсролыг аль болох эртнээс буюу бага насанд нь олгож эхлэх нь санхүүгийн суурь мэдлэгтэй, хуримтлуулах дадал хэвшил суусан, санхүүгийн сахилга бат, хариуцлагатай иргэн болон төлөвших үндсэн нөхцөл болно.

Өөрийн хөрөнгө, мөнгийг хэмнэлттэй, үр ашигтай, зөв удирдахтай холбоотой мэдлэг, боловсролыг олж авах хамгийн тохиромжтой үе бол хүүхэд нас юм. Хүүхдийн төлөвшлийн 70 хувь 0-3 насандаа тогтдог гэсэн судалгаа байдаг. Иймээс зарим улсад

санхүүгийн боловсролыг цэцэрлэгийн насанд нь олгож эхэлдэг. Тухайлбал, Австрали улсын Засгийн газар 2013 онд бага насны хүүхдэд санхүүгийн мэдлэг олгох үндэсний стратегийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг цэцэрлэгийн наснаас эхлэн 12 жилийн сургалттай Ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд хийхээр шийдвэрлэжээ.

Бага насны хүүхдэд мөнгөө зөв зүйлд зарцуулах, хуримтлал үүсгэх талаар тэдний нас, сэтгэхүйн онцлогт тохируулан энгийн зүйлээс эхлэн зааж сургахдаа дараах аргуудыг ашиглавал тохиромжтой. Тухайлбал, 3 настайгаас нь эхлэн мөнгөө хадгалах арга ухааныг тоглоомын байдлаар зааж сургах болно. Ингэхдээ мөнгөө нугалж, үрчийлгэхгүй байх, мөнгө хадгалах хайрцаг, авдар, гахайндаа зөв хийх аргаас эхлэх нь зүйтэй. Цаашлаад бүх мөнгөөрөө амттан авч идэлгүй, хагасыг нь хадгалаад байвал хуримтлуулсан мөнгөөрөө илүү сайхан зүйл, тоглоом авч болохыг ойлгуулж, хадгалсан мөнгөөр нь хүсэж байсан зүйлийг нь авч өгөх хэрэгтэй. Үүний зэрэгцээ мөнгөө юунд зарцуулах талаар зөв шийдвэр гаргахад нь туслах зөвлөгөөг өгч эхэлнэ. Энэ үеэс л хүсэл, хэрэгцээгээ ялгах анхны алхмыг нь хийлгэх хэрэгтэй.

Мөн санхүүгийн холбогдолтой сэдвүүдээр хүүхдийн сонирхлыг татахуйц, тэдний нас, сэтгэхүйд тохирсон богино хэмжээний бичлэг, DVD, зурагт ном, хэвлэмэл материал, цуврал ном гаргах, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүүхдийн санхүүгийн боловсролд зориулсан нэвтрүүлэг явуулах зэргээр санхүүгийн мэдлэгийг түгээж болно. Сургуулийн насны хүүхдэд зориулсан эдгээр сургалтын материал, хэрэглэгдэхүүн нь сурагчдын амьдралд хамгийн ойр, бодит жишээн дээр тулгуурласан байх нь илүү тохиромжтой, үр дүнтэй байна.

Зарим улсад мөнгө олох, хадгалах, хуримтлуулах, удирдахтай холбоотой мэдлэгийг олгохдоо интерактив тоглоомыг ашигладаг. Ийм төрлийн тоглоомуудыг интернетээс олж болно. Хэдийгээр санхүүгийн боловсрол эзэмшсэн, мэргэжлийн багшаар хичээл заалгах нь илүү үр дүнтэй ч бага насны хүүхдэд зориулсан санхүүгийн цахим хуудсыг ашиглан мэдлэг олгох аргыг хэрэглэх боломжтой юм. Жишээлбэл, АНУ-ын Калифорнийн мужийн Хөдөө аж ахуй, байгалийн нөөцийн их сургууль өсвөр насны хүүхдэд санхүүгийн суурь мэдлэг олгодог <http://moneytalks.ucanr.edu> цахим хуудсыг ажиллуулдаг.

Санхүүгийн шийдвэр гаргахын тулд санхүүгийн тооцоолуур (хадгаламжийн, хүүний, зээлийн, төсвийн)-уудыг ашиглах аргыг бага насны хүүхдэд зааж өгөх хэрэгтэй. Энэ нь тооны машинд тоо оруулахтай адил хялбар бөгөөд уншиж бичиж сурсан, тоо мэддэг бүх хүн насны хязгааргүйгээр ашиглах боломжтой байдаг давуу талтай юм. Жишээ нь, Монголбанкны Санхүүгийн боловсрол аппликейшн ашиглаж болно.

Бага насны хүүхдэд санхүүгийн мэдлэг олгоход боловсролын байгууллага, эцэг, эхийн хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой. Зөвхөн сургууль, цэцэрлэгт хичээл заах бус, эцэг эхчүүд өөрсдөө санхүүгийн хариуцлагатай, арвич, хямгач байж, санхүүгийн зөв шийдвэр гаргадаг байх нь хамгийн чухал. Хүүхдийнхээ дэргэд байнга мөнгөний гачигдалтай байдлаа ярих, мөнгөтэй холбоотой хэрүүл хийх, зээлээ хугацаанд нь төлж чадахгүй байгаагаа зөвтгөж ярих зэрэг нь хүүхдэд санхүүгийн буруу хандлага төлөвшүүлэхэд хүргэнэ. Харин өрхийн төсвөө зохиохдоо хүүхдүүдээ оролцуулж, тэдний саналыг сонсон, хэрхэн орлого олж байгаа болон түүнийг зөв зүйлд, хэмнэлттэй зарцуулах талаар ярилцах хэрэгтэй.

Түүнчлэн санхүүгийн мэдлэг олгох хичээл зааж байгаа багш нь өөрөө үлгэрлэн дагуулагч байх хэрэгтэй. Цалингаас цалингийн хооронд, зээлнээс зээлний хооронд амьдардаг багшийн ярьж байгаа зүйл, бодит амьдралтай нь зөрчилдөж байгааг сурагчид харж л байгаа. Тиймээс өөрөө бага ч гэсэн мөнгөн хадгаламж үүсгэж, авсан зээлээ цаг хугацаанд нь бүрэн төлж барагдуулж байх нь сурагчдад зөв үлгэр болно.

Манай орны хувьд сургуульд хамрагдалтын түвшин харьцангуй өндөр байдаг нь бага, дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт санхүү, бизнесийн хичээлийг оруулах замаар сурагчдад санхүүгийн мэдлэг олгох боломжийг бүрдүүлж байгаа юм. Хэрэв бие даасан хичээл оруулах боломжгүй бол математик, нийгмийн тухай мэдлэг зэрэг бусад хичээлийн агуулгатай уялдуулан санхүүгийн мэдлэг олгож болно. Тухайлбал, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тооцооллын томъёог математикийн хичээлд ашиглан, сурагчдаар санхүүгийн тооцоолол хийлгэвэл илүү дүр дүнтэй байна. Хэдийгээр ерөнхий боловсролын сургуульд санхүүгийн холбогдолтой сэдвүүд зарим хичээлийн хөтөлбөрт тусгагдан орж байгаа боловч ихэвчлэн макро эдийн засгийн түвшинг хамарч байна. Иймээс хувь хүн, өрхийн түвшинд авч үзэж санхүүгийн мэдлэг олгох шаардлага урган гарч байгаа юм.

2015 онд Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг батлан, хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын "Бизнес судлал" хичээлийн сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулж, 10, 11-р ангийн сурах бичиг, 10-р ангийн багшийн ном хэвлэгдэн гарсан. "Бизнес судлал" хичээлийг 10,11,12-р ангид орохоор төлөвлөсөн бөгөөд зарим сургуулийн 10, 11 дүгээр ангид уг хичээлийг зааж байна. Цаашид бага ангиас эхлэн санхүүгийн мэдлэг олгох зорилтын хүрээнд бага, суурь түвшинд санхүүгийн мэдлэг олгох хичээлийн агуулга, зөвлөмж боловсруулах ажил хийгдэж байна.



"САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ-МИНИЙ АМЬДРАЛД"

Монголбанкны Санхүүгийн боловсролын аяны хүрээнд зарласан эссе бичлэгийн уралдааны тэргүүн байрын бүтээл. (СЭЗИС-ийн оюутан Б.Бямбасүрэн)

Бенжамин Франклин "Бяцхан зардлаас болгоомжил. Багахан нэвчилт агуу хөлөг онгоцыг живүүлж чаддаг." гэж хэлсэн байдаг. Түүний хэлсэнчлэн хүн өөрийн сууж яваа хөлөг онгоцоо живүүлэхгүйн тулд жижиг зардалд ч анхаарлаа хандуулж чаддаг байх хэрэгтэй. Хэн ч санхүүгийн зарцуулалтын талаарх мэдлэггүйгээр сая саяар нь олсон ч хуримтлуулж, хадгалж чаддаггүй. Зарим хүмүүс "эдийн засаг, санхүү" гэсэн үгсийг сонсоод эгэл хүний амьдралаас хол тасархай ойлголт гэж боддог. Гэвч энэ нь хүн бүрийн өдөр тутмын худалдан авалт, бяцхан ашиг болон зардлыг ч багтаадаг өргөн хүрээтэй шинжлэх ухаан юм. Санхүүг ойлгохын тулд хүн юуны түрүүнд хэрэгцээ болон хүсэл гэсэн ойлголтуудын ялгааг мэдэх шаардлагатай. Хүний хэрэгцээнд ус, агаар, хувцас, гутал зэрэг хүнд зайлшгүй шаардлагатай өдөр тутмын хэрэглээний зүйлс багтдаг. Харин хүсэл гэдэг нь шинэ утас, 80 инчийн дэлгэцтэй зурагт, гадаадад аялах гэх зүйлсийг хамруулсан ойлголт юм. Хүн ус агааргүй

бол амьдарч үл чадна харин ухаалаг утасгүй байсан ч амьдарч чадна. Хүн бүр өөрийн санхүүг зохицуулж чадвал хэрэггүй зүйлд мөнгө үрэхээ зогсоож мөнгөний хувьд гачигдах зүйлгүй амьдрах боломжтой. Иргэн бүр өөрийн санхүүг зохицуулж сурахад асар том дам нөлөө буй. Иргэдийн амьжиргааны төвшин нь улсын эдийн засагтай шууд хамааралтай байдаг. Иргэн баян бол улс баян. Энэ нь улс хөгжвөл иргэд хөгжинө гэсэн утгаар бус иргэд хөгжвөл улс хөгжинө гэсэн утга агуулна.

Юуны өмнө, хүн бүр эцэг эхээс санхүүгийн боловсролын анхны мэдэгдэхүүнийг олж авдаг. Хэдхэн төгрөг гээд хүүхдүүддээ өөгшүүлээд байгаа хүмүүсийн хөл ихтэй газар хүүхдүүдийн нүдэн тусах газар олноор байрласан, мөнгө хийхээр муухан шиг бохь, атга чихэр, резин бөмбөг, шивээс гээд төрөл бүрийн жижиг сажиг зүйлс гаргаж өгдөг эдгээр машинууд зэрэг нь бидний бодож байгаа шиг тийм хямд зүйл мөн үү? Үнэхээр эдгээр машинууд хүүхдүүдэд баяр баясгалан өгч чадаж

байна уу, эсвэл зүгээр тэднийг мөнгөө цоорхой шуудай уруу хийхийг сургаж байна уу?¹ Миний хувьд аав маань төрийн албан хаагч, ээж маань хувийн байгууллагын нягтлан бодогчоор ажилладаг. Намайг бага байхад аав ээжийн цалин буусан өдөр зээл, хадгаламждаа хэдэн төгрөг нэмж хийх, машин тэрэгний засвар, хоол хүнс гэх мэт зүйлст хэдэн төгрөг зарцуулах талаар ярилцдаг байсан. Аав ээжийн энэ ярианаас олсон мөнгөө хэрхэн зарцуулах, юунд хуваарилахыг сурсан. Илүү зардал гаргахгүйн тулд аливаа зүйлээс ганцыг л авч өгдөг байсан. Иймээс надад нэгээс дээш зүйл таалагдаж байсан ч гэсэн аль нэгийг нь сонгох шаардлагатай тулгардаг байсан маань одоо надад чадвар болон үлдэж байна. Илүү зүйлд мөнгө үрэх боломж ч олддоггүй байснаас болж түргэн хугацаанд дүгнэлт хийж шийдвэр гаргаж сурсан. Түүнчлэн намайг дунд сургуульд орсон үеэс ээж минь надад банкны карт өгч сар бүр тэнд минь мөнгө хийж өгдөг болсон. Сар дуусахаас өмнө мөнгөө дуусвал нэмж мөнгө өгдөггүй байсан бөгөөд энэ нь мөн л надад мөнгөө өөрөө зарцуулах тал дээр туршлага болж өгсөн. Надад тодорхой хязгаартай мөнгө байгаа учраас хэчнээн таалагдаж байсан ч хүний хэрэгцээнд нийцэхгүй зүйлс байвал худалдаж авч болохгүй тал дээр суралцсан.

Түүнчлэн, бид хэмнэж сурахын тулд, яагаад хэмнэх ёстой вэ гэдгийг ойлгох хэрэгтэй. Хэрэгцээт эрсдэлийг үүрч хөрөнгө оруулалт хийж чаддаг байх нь дараагийн чухал санхүүгийн боловсрол болно. Энэ нь хадгаламжийн данс, сертификат гэх санхүүгийн алхмуудаас гадна хувьцаа бондтой эртнээс танилцах хэрэгтэй гэсэн үг юм. Мэдээж Монголын санхүүгийн зах зээлд хувьцаа, бондын арилжаа хаалттай биш боловч ихэнх хүмүүс үүнийг төдийлөн ашигладаггүй. Энэ нь нэг талаас техник технологи хөгжсөн ч онлайн брокерууд ажилладаггүйтэй холбоотой. Үүнээс авч үзэхэд санхүү гэх ойлголтын цаана ямар их мэдээлэл явдаг нь харагдах мэт. Хүмүүс хүүхдээ баян болгохын тулд хөдөлмөрлөх биш, санхүүгээ сайн зохицуулж

сурах хэрэгтэй. Энэ нь тэдний хүүхдийг угаас чинээлэг амьдрахад асар их нөлөөлөөд зогсохгүй өөрсдийн амьдралыг ч товхинуулах боломжийг олгодог. Эдийн засагт гардаг алдагдсан боломжийн өртөг гэх ойлголт үүнд тусалж өгнө. Яагаад гэвэл бүх зүйл нөөцтэй, хэрвээ ч нэг зүйлийг худалдаж авбал өөр зүйлийг худалдаж авах боломжоо алдана гэсэн үг. Эдийн засгийн үндсэн ухагдахуун нь хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээг хангахад оршино. Иймээс бид хамгийн оновчтой зүйлдээ хөрөнгө оруулах нь чухал.

Санхүү гэдэг бол хадгалалт болон зарцуулалт бөгөөд ерөнхий объект нь хөрөнгө оруулалт. Хэрэв бид зөв зүйлд хөрөнгө оруулж чадвал энэ бол үүний үр өгөөж нь хэмжээлшгүй. Харин бид үүнийг өөрсдийн хүсэл дээр тулгуурлан зарцуулбал энэ бол үргүй зардал юм. Дуслыг хураавал далай гэдэгчлэн хадгалалт их үргүй зардал бага бол мөнгө цуглараад л байна. Эсрэгээрээ нэвчилт байх юм бол бага багаар дуссаар нэг л мэдэхэд их хөрөнгийг алдаж болно. Хүн хэчнээн их мөнгө олдог байлаа гээд үүнийг хүсэлдээ хөтлөгдөн “үрвэл” тэр хүн хэзээ ч чинээлэг амьдарч хуримтлал үүсгэж чадахгүй. Хүн уг хүсэл болон хэрэгцээ хүчин зүйлсийн ялгааг олсон тохиолдолд нэвчилт үгүй болно. Ард иргэд нь чинээлэг, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн өндөр бол тухайн улсыг баян гэдэг. Улсын иргэн бүрийн зарцуулалт төрийн зарцуулалт л гэсэн үг. Санхүүгийн талаар багахан мэдлэгтэй байхад хүн хөрөнгө оруулалт, эдийн засгийн анхан шатны судалдаг зүйлс бидний өөрсдийн амьдралын жижиг зүйлсээс эхтэй гэдгийг ойлгодог. Цаашлаад улс орны ирээдүй, бидний үр хойч бидний санхүүг залгамжлан авч үлдэнэ. Хүн өөрийн хүүхдүүддээ мөнгө олох аргыг биш мөнгөтэй байх аргыг зааж өгвөл энэ нь жинхэнэ санхүү юм. Тиймээс үүнийгээ амьдрал дээр хэрэгжүүлж чадсан хүмүүс их цалин олдоггүй байвч мэддэггүй нэгнээс элбэг хангалуун амьдарч чаддаг. Үүнээс санхүүгийн боловсрол хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

¹ Д., Баярсайхан. “МӨНГӨ Ба ХҮҮХЭД.” Цаг Төр, 26 Dec. 2011,



МЭДЭГДЭЛ

Сүүлийн үед Монголбанкинд ирж буй мэдээллийг дэнслэн үзэж дараах мэдэгдэл гаргахаар шийдэв.

Цалин, тэтгэвэр, эд хөрөнгөө барьцаалан банкнаас зээл авч, түүгээрээ криптовалют худалдан авч буй зарим иргэдийн талаар надад сонсогдож эхэлсэн нь миний сэтгэлийг ихэд зовоож, түгшүүр төрүүлж байгааг нуухгүй хэлье.

Криптовалют гэдэг нь нэгдсэн нэг удирдлагагүй буюу аль нэг Төв банкны зохицуулалтгүй, бие даасан байдалтай, цахим хэлбэрийн тооцооны хэрэгсэл юм.

Монголбанк нь криптовалютыг мөнгөн тэмдэгт хэмээн үзэхгүй болохыг юуны өмнө мэдэгдье. Тэр нь төлбөр тооцооны хууль ёсны бодит хэрэгсэл болж чадахгүй юм. Мөнгөн тэмдэгтийг зөвхөн улс орны Төв банкууд л гаргах, хэвлэх эрхтэй. Монгол Улсын Төв банкны баталгаатай хууль ёсны мөнгөн тэмдэгт, төлбөрийн хэрэгсэл бол төгрөг юм.

Криптовалютын эрсдэлийн талаар дүгнэлт гаргах ажлын хэсэг Монголбанк дээр байгуулан судалгаа хийлгэв. Судалгаанд үндэслэн блокчейн технологид суурилсан криптовалютыг хөрөнгө оруулалт хэлбэрээр худалдан авахаас сэрэмжлүүлж байна. Иргэд хохирон үлдэхээс болгоомжлуулах нь миний үүрэг.

Улс орон, Төрийн байгууллагын хяналт шалгалтаас хол, зохицуулалт байхгүй бүтээгдэхүүн болох криптовалют худалдан авахдаа эрсдэлээ сайтар тооцон үзэж, долоо хэмжиж байж нэг огтлох зарчмаар хянуур, хашир хандахыг уриалж байна. Өөрийнхөө сайн мэддэг, чаддаг зүйлдээ эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийхийг зөвлөж байна.

Хэрэв улс орнуудын төрийн холбогдох байгууллагаас криптовалютын хэрэглээг хязгаарлаж эхэлбэл биткойн зэрэг криптовалютын үнэ цэнэ маш хурдтайгаар унах эрсдэлтэйг анхааруулья.

Учир нь криптовалютаар дамжуулан татвараас зайлсхийх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явагдаж байна хэмээн нотлогдвол түүнийг хориглох магадлал өндөр юм. Энэ талаар Монголбанк урд нь удаа дараа байр сууриа тодорхой илэрхийлж байсан болно.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАЯРТСАЙХАН

2018 он.



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНГИЙН ЯАМ



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



Алсын хараа:

Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах



Зорилт:

- Иргэдийн хувийн санхүүгээ зохистой удирдах чадварыг дээшлүүлэх;
- Иргэдийг санхүүгийн залилангаас өөрийгөө хамгаалах чадвартай болгох;
- Хувь хүн, бизнес эрхлэгчид өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хэрэгцээтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сонгож Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

Стратегийн чиглэлүүд



Сургуулийн насныхан



Залуу үеийнхэн



Хөдөө, орон нутгийн иргэд



Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл

Хэрэгжилт



ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт "Бизнес судлал" сонгон суралцах хичээл шинээр нэвтрүүлэв.



Их дээд сургуулиудад мэргэжил харгалзахгүйгээр үзэх "Хувь хүний санхүү" хичээл боловсруулагдав.



Орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох 13 төрлийн гарын авлага бэлэн болов.



www.sankhuuginbolovсрол.mn цахим хуудас ашиглалтанд оруулав. Мөн "Төсөвчин" - үнэгүй аппликейшн iOS, Android систем дээр гарав.

“САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ” АЯН

2017.10.02 - 2017.12.31



САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ
www.sankhuuginbolovсрол.mn



Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн талаарх мэдээллийг дараах хаягуудаар авна уу.



www.mongolbank.mn



sankhuuginbolovсрол.mn



@mongolbank_mn



@mongolbank_mn



[mongolbank](https://www.youtube.com/mongolbank)



11-310081